



ЗАМ, ТЭЭВРИЙН  
ХӨГЖЛИЙН ЯАМ



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (БОНМТ)

ТӨВ АЙМГИЙН УГТААЛ ЦАЙДАМ, ЦЭЭЛ СУМЫН АВТО ЗАМЫН  
АЖИЛ

Монгол Улсын Зам тээврийн холболт ба логистикийг сайжруулах  
төсөл

## АГУУЛГА

Монгол Улсын Зам тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл.....	1
1. Танилцуулга .....	3
Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
БОНМТ-ний зорилго ба хамрах хүрээ.....	4
2. Дэд төсөл хэрэгжих газрын байгаль орчин, нийгэм, эдийн засгийн суурь нөхцлүүд .....	7
Газарзүй ба геоморфологи.....	8
Гадаргын ус.....	9
Уур амьсгал.....	10
Гүний ус.....	12
Хөрс .....	12
Өвс, ургамал .....	13
Ан амьтан.....	13
Нийгэм-эдийн засаг.....	14
Ложистик ба уялдаа холбоо .....	14
Биет соёлын нөөц.....	16
3. Хууль эрх зүй, бодлогын хүрээний ажил, зохицуулалтын шаардлага .....	17
3.1 Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний ажил .....	17
3.2 Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулалт, стандарт.....	19
3.2.1 Монгол Улсын байгаль орчны бодлого зохицуулалтын баримт бичгүүд .....	19
одорхойлох замаар улс орны иргэнийг чухалчлан үзнэ. ....	19
3.3 Монгол Улсын хууль тогтоомж, Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн стандартуудын хоорондын зөрүүнд хийсэн шинжилгээ .....	22
Монгол Улсын байгаль орчны стандартууд.....	25
Ус.....	28
Гадаргын ус.....	32
Хөрс .....	33
Дуу чимээ .....	33
Бусад холбогдох стандартууд .....	34
Тусгай хамгаалалттай газар нутаг .....	34
4. Дэд төслийн Байгаль орчин, нийгэмд үзүүлэх боломжит нөлөө .....	34
4.1 Байгаль орчинд үзүүлэх боломжит нөлөөлөл (барилгын болон ашиглалтын үе шат) .....	34

## 1. ТАНИЛЦУУЛГА

### Төслийн ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Зам тээврийн холболт, логистикийг сайжруулах төсөл нь Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүний өргтийн сүлжээн дэх үүр амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй тээврийн холболт, логистикийн үр ашгийг дээшлүүлэх зорилготой юм.

Санал болгож буй Монгол Улсын Зам, тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл нь махны нэмүү өргтийн сүлжээн дэх логистикийн зардлыг үүсгэгч гурван гол хүчин зүйлийг шийдвэрлэх багц арга хэмжээнүүдээс бүрдэнэ. Эдгээр нь хангалтгүй холбогдох байдал, стратегийн байршил, үр ашигтай логистикийн төвүүд дутмаг, мөн ханган нийлүүлэлтийн сүлжээнд оролцож буй төрөл бүрийн оролцогчдын дундах мэдээллийн тэгш бус байдал болно. Төсөл нь дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд: **Дэд хэсэг 1.2: Орон нутгийн малчдад зориулсан хамгийн сүүлийн-бээрийн холболт**. Энэхүү дэд-бүрэлдэхүүн хэсэг нь хамгийн эцсийн миль холболтыг сайжруулахад авах арга хэмжээний нэг бөгөөд нэн тэргүүний ач холбогдол бүхий орон нутгийн 127 км орчим авто замыг шинэчлэх ажлыг санхүүжүүлэхээс, 76 км авто замын нарийвчилсан зураг төслийг боловсруулж, хэрэгжүүлэхэд бэлэн болгосон.

Энэ БОНМТ нь **Угтаалцайдам, Цээл сумын эцсийн миль холбох замын ажилд** төвлөрнө. Санал болгож буй замын ажлын нарийвчилсан зураг төслийг 2018 онд Зам тээвэр, хөгжлийн яам нь “Орон нутгийн замыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 1. Бүрэлдэхүүн 1.2 дахь хэсэг: орон нутгийн малчдыг эцсийн миль холбох зам

Зам	Нарийвчилсан зураг төсөл байгаа эсэх	Үрт (км)
Төв аймаг, Цээл сум	Байгаа	23.7
Төв аймаг, Угтаалцайдам сум	Байгаа	52.27
<b>Нийт</b>		<b>75.97</b>

Энэ нь малчдыг улсын чанартай авто замын сүлжээтэй холбодог орон нутгийн авто замыг сайжруулах үйл ажиллагаа юм. Монгол Улсын мах нийлүүлэх сүлжээний хүрээнд, энэхүү эцсийн шат нь малчдын амьжиргааг хязгаарлах гол хүчин зүйл болохоос гадна бүх сүлжээний хувьд буюу оператор, боловсруулагч, тээвэрлэгч, жижиглэн худалдаалагч, экспортлогчдын хувьд ч мөн маш чухал юм.

ЗТХЯ бүх аймгийн төвийг нийслэл Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбох зорилго тавьсан. Одоогийн байдлаар 20 аймаг, 105 сумыг хатуу хучилттай замаар холбоод байна. Нутгийн зам төсөл нь хөдөө аж ахуйн салбарыг дэмжих, эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулж орон нутгийн иргэдийг дэмжих зорилгоор 45 сумын төвийг аймгийн төвүүдтэй нь хатуу хучилттай замаар холбох зорилго тавьсан. (ЗТХЯ, 2021 он) Энэхүү зорилгын хүрээнд Угтаалцайдам, Цээл сумын эцсийн миль холбох хоёр замыг төслийг хүрээнд санхүүжүүлэх санал оруулаад байна.

БОНМТ нь “Монгол Улсын зам тээврийн холболт, ложистикийг сайжруулах төсөл” Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ (БОНМХ)-нд тусгасан үүргүүдийн үр ашиг, учирч болох серөг үр дагавруудыг бууруулах арга хэмжээ, эрсдлийг хэмжих, шалгах чухал хэрэгсэл болно. БОНМХ-ний Хавсралт 7-д дэд төсөл буюу БОНМТ-г боловсруулахаар заасан. Энэхүү **БОНМТ нь Төв аймгийн Угтаалцайдам, Цээл сумын хэсэг зам барих** (цаашид “Угтаалцайдам, Цээл сумын замын БОНМТ” гэх)-д зориулсан удирдамжийг агуулсан.

Энэхүү дэд төслийн БОНМТ-г “MCPCgr” ХХК-ийн 2018 онд ЗТХЯ-нд бэлтгэн өгсөн нарийвчилсан зураг төслийн ажилд суурилсан болно. Эш авсан эх сурвалжуудыг тайланд дурдав.


### **БОНМТ-ний зорилго ба хамрах хүрээ**

Энэхүү БОНМТ нь төслийн Бүрэлдэхүүн 1.2 дахь хэсэг-ийн орон нутгийн малчдын эцсийн миль холболтын хүрээнд төлөвлөсөн шинэ авто замуудын барилгын ажлын байгаль орчин, нийгмийн хамгаалал, нөлөөллийг бууруулах шаардлагуудыг мөрдөх, үр дүнг хэмжих байгаль, орчин нийгмийн удирдамжуудыг тодорхойлно

Энэхүү төлөвлөгөө нь төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үед гарч болох байгаль орчин, нийгэмд учирч болохуйц томоохон эрсдлүүдийг хянах, түүнийг байж болох хамгийн эрсдэлгүй хэмжээнд хүртэл бууруулах институцийн арга хэмжээний цогц юм. Тус төлөвлөгөөг боловсруулахдаа Дэлхийн Банкны болон үндэсний байгаль орчин, эрүүл ахуйн холбогдох стандартуудад нийцүүлэн, ижил төстэй төслүүдийн БОНМТ, олон улсын сайн туршлага, зааварчилгаанд үндэслэсэн. Төслийн байгаль орчны менежментийг үр ашигтай хөтлөн явуулах дараах бүрэлдэхүүнүүдийг тусгасан. Үүнд: (i) байгаль орчин, нийгмийн суурь үзүүлэлтүүд (ii) хууль тогтоомж, бодлогын тогтолцоо, ба зохицуулалтын шаардлагууд (iii) байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөллүүд (iv) байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд, хамгаалах үйл ажиллагаанууд (v) хэрэгжүүлэх зохицуулалт, үүрэг хариуцлага ба чадавх бэхжүүлэлт (vi) мэдээлэл ил болгох ба олон нийттэй зөвлөлдөх (vii) гомдол барагдуулах механизм (viii) хяналт тавих ба тайлagnалт (ix) байгаль орчны мониторингийн шаардлагууд багтана. Энэхүү баримт бичиг нь төслийн гэрээт гүйцэтгэгч нарт нэн хамааралтай бөгөөд дэд төслийн барилгын гэрээнд нь хавсралтаар тусгагдана.

Энэхүү БОНМТ-г дараахтай уядуулах зорилгоор төслийг гэрээг байгуулахын өмнө шинэчилж, Дэлхийн Банкаар батлуулна. Үүнд (i) техникийн шаардлагууд, (ii) нарийвчилсан зураг төсөл дэх өөрчлөлтүүд, хэрэв байгаа бол (iii) биологийн олон янз байдал болон соёлын өвийн хээрийн шинжилгээний дүгнэлтийг тусгах, (iv) Монгол Улсын Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн шаардлагын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ)-ийн үеэр тодорхойлсон нэмэлт нөлөөлөл ба тэдгээрийг бууруулах арга хэмжээнүүд.

Зураг 1 Төв аймгийн Угтаалцайдам, Цээл сүмдүн одоо ашиглагддаг хүчилтгүй зам



Замын чиглэлүүдийн нарийвчилсан байршил, уртраг, өргөргийн дугаарыг энэ БОНМТ-ний Хавсралт 3-аас үзэж болно.

Нарийвчилсан зураг төслийг “Замын зураг төсөл” ЗБНД 22-004-2016 үндэсний стандартын дагуу боловсруулсан бөгөөд доорх хүснэгтэд техникийн үзүүлэлтүүдийг харуулав.

Хүснэгт 2. Зураг төслийн үзүүлэлтүүд. МСРСГР 2018 он

№	Зураг төслийн үзүүлэлт	ЗБНД 22-004-2016 нормын үзүүлэлтүүд	Сонгосон үзүүлэлтүүд			
1	Замын ангилал ба зэрэглэл	Зэрэглэл 2А. Аймаг, сум хоорондын болон дүүргийн доторх зорчих хөдөлгөөний хэрэгцээг хангахад зориулсан хуримтлуулагч зам	Төв аймаг, Угтаалцайдам, Цээл сүмдүн төвийг холбох зам			
			Xэсэг 1	Xэсэг 2	Xэсэг 3	Xэсэг 5
2	Жилийн дундаж хоногийн хөдөлгөөний эрчим	200-аас их				
3	Төсөллөлтийн тодорхойлолт	2A-Xр3-3ХГ-2-70	2A-Xр3-3ХГ-2-70			
4	Тооцоот хурд: тэгш тал газар	70-80 км/цаг	80		60	
5	Нугачаатай газар	60 км/цаг	80		60	
6	Уулархаг газар	50 км/цаг	60		60	

7 Тооцоот хугацаа	15	15
8 Хөдөлгөөний үялчилгээний түвшин	D, E	D
9 Трассын шулуун хэсгийн хамгийн их урт	5000м	1975 2180 2254 380
10 Хамгийн их дагуу налуу: тэгш тал газарт	6%	3%
11 Хамгийн их дагуу налуу: нугачаатай газарт	7%	5 3.6 5
12 Хамгийн их дагуу налуу: уулархаг газарт	9%	5.6 5.99 5.99
13 Хэвтээ муруйн хамгийн бага радиус	250 м	300 400 300 600
14 Зорчих зурvasын өргөн	6.0-7.0м	6.0м
15 ГХөдөлгөөний зурvasын хучилтын өргөн	7.0м	7.0м
16 Хөвөөний өргөн	1.5-2.0	2.0м
17 Үүнээс хучилттай хөвөөний өргөн		0.5м
18 Зогсох үеийн хамгийн бага үзэгдэх зай	130м	140м
Гүйцэж түрүүлэх үеийн хамгийн бага үзэгдэх 19 зай	245м	560м
20 Хучилтын хөндлөн налуу	2%	2%


Одоо ашиглаж буй шороон замын суурин дээр Цээл суманд 23.7 км, Угтаалцайдам суманд 52.27 км урттай хатуу хучилттай зам баригдана. Байгаа материалынхаа хэмжээнд тулгуурлан INDOR PAVEMENT 9 програм<sup>1</sup> ашиглан хучилтын хэмжээг гаргасан. Доорх зурагт үзүүлсний дагуу асфальт бетонон хучилтыг санал болгов.



Зураг 2 Санал болгож буй бүтэц. Эх сурвалж:  
MCPCgr Нарийвчилсан зураг төслийн тайлбар

Замын босоо бүтэц нь Монголын зураг төслийн стандартын дагуу буюу уулархаг газарт зориулсан IIA ангиллаар хийгдэнэ. Ихэнх хэсэгтээ  $-3.0\text{m}^*2$  ба 2%-ийн налуутай, хатуу хучилттай эргийн өргөн  $-0.5\text{m}^*2$ , хучилтгүй эргийн өргөн  $-1.5\text{m}^*2$  харьцаатай 4% налуу байна. Нийт эргийн өргөн  $-10.0\text{m}$ .

<sup>1</sup> IndorPavement програм нь нийтийн зориулалттай хурдны зам, гудамж, авто замын хучилтыг тооцоолох зориулалттай. Эх сурвалж: <https://www.indorsoft.ru/products/pavement/>



Зураг 3 Санал болгоод буй замын загвар. Эх сурвалж: MCPCgr 2018 он.

Зураг төслийн нэмэлт шаардлагуудыг төслийн хэрэгжилтийн явцад шинэчилсэн БОНМТ-г гэрээт гүйцэтгэгч нар мөрдөхөд зориулсан ТУА-наас тодорхойлж өгнө. Гэхдээ автозамын барилгын ажлын суурилуулалт, бэлтгэл ажилд дараах ерөнхий ажлууд багтана. Үүнд:

- Суурь газрыг бэлдэх, ажлын талбай, барилгын кэмпүүдийг байгуулах
- Бутлах ажиллагаа, бетон зуурмагийн бэлтгэл суурилуулалтын төлөвлөгөө
- Барилгад шаардагдах материалын нийлүүлэлт (машин, техник, барилгын тоног төхөөрөмж)
- Түр байрлуулах тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад босгох
- Ерөнхий цэвэрлэгээ, шаардлагатай газар нь мод тайрч, талбай чөлөөлөх
- Шуудуу ухах

ТУА нь түр ашиглах, ачаа тээврийн замыг сонгож бэлдэх бөгөөд БОНМТ-г тухай бүрт шинэчлэн засна.


Зам барилгын үед замын хүчилтанд элс, бетон, цардас зэрэг шаардлагатай бөгөөд бетон зуурах хольц, ус гэх мэтийн ихэнхийг орон нутгийн эх үүсвэрээр хангана. Бүх түүхий эдийг зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээс нийлүүлнэ.

## **2. ДЭД ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ НӨХЦЛҮҮД**

### Суурь мэдээллийн эх сурвалжууд

Ковид-19-ийн нөхцөл байдлын хязгаарлалтаас шалтгаалан энэхүү төлөвлөгөөний суурь мэдээллийг олдож байгаа наад захын мэдээллүүдийг цуглуулахаас гадна орон нутгийн иргэдийн төлөөлөлтэй уулзалт хийх журмаар цуглуулж эмхэтгэсэн.

Төв аймгийн Угтаалцайдам сум Улаанбаатар хотоос 134 км, харин Цээл сум 188 км зйтай.




Зураг 4. Төв аймгийн газар нутаг

#### Газарзүй ба геоморфологи


Төслийн талбайг бүрдүүлж буй газарзүйн бүтэц нь Хэнтийн нурууны бүрэлдэхүүнд орох ба далайн түвшнээс дээш 1215 метр өргөгдсөн. Тус уул нуруу 280-350 сая жилийн өмнө бүрэлдсэн тунамал ба хувирмал чулуулгаас бүрддэг бөгөөд боржин чулуу нь 130 сая жилийн өмнө буюу Юрийн галавын төгстөл хэсэгт хамаарах үед бүрэлдэн тогтсон байна. Уулын бэл, түү жалга хавиар дөрөвдөгч үеэс үлдсэн коллуви болон сул тунамал чулуулагтай. Тухайн талбайн газар хөдлөлтийн эрсдэл 4-6 магнитуд.

Зураг 5. Төв аймаг, төслийн байршилын өндөршлийн ялгаа (м)-г харуулсан цахим өндөршилтийн загвар



Монголын газар нутаг дэлхийн мөнх цэвдгийн өмнөд шилжилтийн бүсэд байрладаг. Тус бүс нь харьцангуй сийрэг цэвдэгтэйгээрээ онцлогтой. Монголд мөнх цэвдэг нь дотроо таван дэд бүсэд хуваагддаг. Үүнд: (i) Дэд бүс 1: үргэлжилсэн; (ii) Дэд бүс 2: үргэлжилсэн бүс/тасархай (iii) Дэд бүс 3. сийрэг тархалттай (iv) Дэд бүс 4. ховор тархалттай (v) Дэд бүс 5. улирлын чанартай цэвдэг багтана. Уг төслийн талбай нь улирлын чанартай дэд бүсэд (v) хамаарна. Иймд тус талбайн газар нь агаарын хэмээс шалтгаалан хөлдөж гэсэх ба цэвдгээс хамааралгүй. Угтаалцайдамын төслийн талбай нь тогтолцоогүй бүсэд хамаарна.


**Зураг 6. Төслийн замын мөнх цэвдэгийн бүсүүд**



### Гадаргын ус

Цээл сумын газар нутаг Орхон-Тамирын голын сав газар байрладаг бол Угтаалцайдам сүм Туул голын сав газар байрладаг. Туул голоос ойролцоогоор 40 км зайд байрлана. Туул гол нь нийт 700 орчим км урт, 49,840 км<sup>3</sup> ус тогтоох талбайтай. Угтаалцайдамын зам доорх зураг дээр харагдаж буй голын сайран дунд байрлаж байна.

**Зураг 7. Төв аймаг дах гадаргын ус**



## Үүр амьсгал

Уг төслийн талбай сэруүн бүсэд байрлах бөгөөд эрс тэс уур амьсгалтай ба өвөл нь урт зүн нь богино байна. Төслийн талбайд бүртгэгдсэн хамгийн хүйтэн агаарын хэм 1954 онд  $-54^{\circ}\text{C}$  байсан бол хамгийн халуун нь 2005 онд  $+39.5^{\circ}\text{C}$  гэж бүртгэгджээ. Сарын агаарын дундаж хэм нэгдүгээр сард  $-21.0^{\circ}\text{C}$ -аас долдугаар сарын  $+17.7^{\circ}\text{C}$ -ын хооронд хэлбэлзэнэ. Жилийн дундаж агаарын хэм бүүлийн 10 жилийн дунджаар  $-0.58^{\circ}\text{C}$  байна. Жилд хөлдөх температуртай өдөр 11-р сараас 3-р сар хүртэл 130 өдөр үргэлжилнэ.

Хүснэгт 3. Төв аймгийн 2012-2017 оны агаарын хэм

Year	Jan	Feb	March	April	May	June	July	Aug	Sep	Oct	Nov	Dec	Annual Mean
2012	-24.6	-20.8	-9.5	1.4	9.8	13.4	16.2	14.1	10.0	-1.5	-13.5	-23.1	-2.3
2013	-19.8	-20.5	-7.2	-1.2	10.2	14.1	16.3	14.3	8.1	-0.1	-9.0	-16.0	-0.9
2014	-17.7	-19.1	-5.7	5.9	7.1	14.0	16.4	14.9	8.7	1.7	-9.6	-17.5	-0.1
2015	-15.5	-13.9	-7.8	2.6	7.4	15.4	18.4	17.3	9.3	1.8	-12.1	-15.4	0.6
2016	-24.3	-16.3	-5.6	2.2	8.0	14.5	19.9	16.7	9.7	-2.8	-13.4	-14.2	-0.5
2017	-18.7	-13.6	-5.5	4.0	11.7	18.0	19.7	14.3	8.5	0.1	-12.7	-16.7	0.8

Source: Meteorological Monitoring Station in Zuunmod, 2018

Хамгийн ойр байрлах ус, цаг уурын шинжилгээний станцын сүүлийн 10 жилийн мэдээгээр уг төслийн талбай дахь жилийн дундаж хур тунадасны хэмжээ 222-308 мм, хур тунадасны 85% нь хаврын эхэн сар (5-р сар)-аас намрын сүүл сар (10-р сар)-ын хооронд ордог. Үүнээс бараг 70% нь 6-8 дугаар сард буюу зуны саруудад ордог байна. Өвлийн цагт дунджаар 1.8 см зузаан цас тогтдог.

Хүснэгт 4. Төв аймгийн 2008-2017 оны дундаж хур тунадас

Year	Jan	Feb	Mar	Apr	May	June	July	Aug	Sep	Oct	Nov	Dec	Annual
2008	1.2	0.5	7.3	5.8	15.9	81.8	49.1	59.5	7.8	18.1	1.1	5.9	254.0
2009	0.2	6.0	1.0	1.8	31.0	49.7	73.7	64.0	14.0	13.4	3.5	3.0	261.3
2010	0.7	4.6	15.2	1.8	28.0	32.2	36.2	73.2	15.0	9.4	9.7	0.2	226.2
2011	0.9	8.8	0.0	14.7	27.8	81.5	55.5	27.1	9.0	28.3	12.9	1.9	268.4
2012	0.0	0.5	1.5	5.9	8.1	80.5	112.2	56.9	12.2	7.8	14.5	8.3	308.4
2013	0.3	2.2	5.0	11.9	21.4	44.9	55.5	65.4	7.4	16.0	7.9	1.6	239.5
2014	0.4	3.4	1.2	7.9	56.1	48.2	67.1	22.7	11.5	1.2	0.8	2.3	222.8
2015	0.7	0.5	17.8	18.7	17.8	13.5	115.9	43.6	22.9	6.6	8.5	3.4	269.9
2016	1.0	1.0	18.9	2.7	17.8	56.8	70.6	49.1	38.2	10.1	18.0	0.7	284.9
2017	0.2	0.2	0.3	3.0	7.9	35.5	27.8	145.5	26.7	8.1	11.8	1.9	268.9

Source: Meteorological Monitoring Station in Zuunmod, 2018

Зам барилгын ажилд хамааралтай байж болох, тухайлбал, зам зайрмагтаж хөлдөх, цасан шуурга шуурах гэх мэт зам ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж болохуйц цаг агаарын бусад хүчин зүйлүүдийд бий. Тэдгээр бусад хүчин зүйлүүдийн талаарх мэдээллийг энэ хэсэгт оруулав.

#### Цастай өдрийн тоо

Тус автозамын коридорын дагуух газар нутагт 9 дүгээр сараас 5 дугаар сарын хооронд жилд дунджаар 35-45 цастай өдөр болно. Нийт унах цасны дийлэнх нь 11-12 дугаар сард унана. Эдгээр саруудад Угтаалцайдам, Цээл сумдад сард 5-9 өдөр цастай байна.

#### Хүснэгт 5. Төслийн талбай дахь цастай өдрийн тоо

Цаг уурын станц	Сарууд									
	9	10	11	12	1	2	3	4	5	
Угтаалцайдам, Цээл сум	0.4	5.8	8.9	9.1	7.0	4.1	4.5	4.4	0.9	

#### Шороон шуурга

Цаг агаарын түүхчилсэн мэдээнээс үзвэл эдгээр сумдад 10-24 удаагийн шороон шуурга ажиглагджээ. Төслийн талбайд жилд 22-35 өдөр шороон шуурга<sup>2</sup>-тай байна. Шороон шуурганы давтамж 4-5 дугаар саруудад салхи, хуурайшилт ихтэй байдгаас шалтгаалан хамгийн их байдаг. Мөн шороон шуурганы идэвхжил хөрсний чийг, цасан бүрхүүл зэрэг цаг уурын бусад нөхцлүүдээс хамаардаг. Шороон шуурга нь замын хөдөлгөөний хувьд үзэгдэх орчин хязгаарлахаас гадна хүмүүс шороон шуурганд удаан хугацаагаар байвал амьсгалын замын асуудал үүсгэх эрсдэлтэй. Зарим тохиолдолд цасан шуургатай ижил байдлаар шороон шуурганаас болж зам дээр шороо ихээр хуримтлагдаж замын хөдөлгөөн ба зам засварын ажилд аюултай нөхцөл байдал бий болно.

#### Хүснэгт 6. Шороон шуургатай өдрийн тоо

Цаг уурын станц	Сарууд											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Угтаалцайдам, Цээл сум	1.4	1.3	1.9	2.7	3.6	2.9	1.8	1.0	1.1	1.5	1.4	1.3

<sup>2</sup> Тоос, элсний ширхгүүд салхины нелөөгөөр агаарт дэгдэж, үзэгдэх орчинг хязгаарладаг цаг агаарын үзэгдэл


## Гүний ус

Монгол Улсын хувьд ахуйн хэрэглээ, аж үйлдвэрт ашиглах гол эх үүсвэр нь гүний ус. Хүн амын 99% нь үндны усаа гүний усаар хангадаг гэж хэлж болно. Гол мөрнөөс алслагдсан газруудад мал сүргийг улашаадаа гүний худаг ашигладаг.

## Хөрс

Угаалцайдам, Цээл сумдын газар нутаг ерөнхийдөө тал, хөндий, үүл, үүлын бэлийн хөрстэй газарт оршдог.

Зураг 8. Хөрсний ангилал




Уг төсөл хэрэгжих талбай дахь сарын дундаж хөрсөн дээрх температур улирал хоорондын эрс тэс хэлбэлзэлтэй буюу өвлийн цагт -22.5°C, зүн цагт 23°C байна. Хөрсөн дээрх температур 11 дүгээр сараас 3 дугаар сарын хооронд 0 градусаас доош байна.

## Хүснэгт 7. Сарын дундаж хөрсөн дээрх температур


Цаг уурын станц	Сарууд											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Угтаалцайдам , Цээл сум	-22.5	.5	-5.8	5.7	14. 1	21. 5	23. 3	19. 6	11. 6	0. 6	-11.4	-19.5

### Өвс, ургамал

Хэнтийн нурууны бүс нутагт хүш, шинэс, улиас, нарс, хүс, яргай мод зэрэг олон төрлийн мод ургадаг. Чихэр өвс, чацааргана, ганга, арц гэх мэт эмийн ургамлууд бүртгэгдсэн байдаг.



Зураг 1 Өвс ургамлын төрөл



Зураг 2 Өвс ургамлын бүрэг

### Ан амьтан

Төв аймгийн нутагт буга, гөрөөс, аргаль, цоохор ирвэс зэрэг 16 төрөл зүйлийн ховордсон хөхтөн амьтнаас гадна 30 төрөл зүйлийн нүүдлийн болон махчин шувуу, дагуур зурам (*Spermophilus dauricus*) LC, тарвага (*Marmota sibirica*) IUCN EN, хярс (*Vulpes corsac*) LC, зэрлэг гахай, баавгай, шилүүс (*Lynx lynx*) LC зэрэг ан амьтад бий. Эдгээр төрөл зүйлүүд ихэвчлэн хүний үйл ажиллагаанаас дайжиж амьдардаг.


Угтаалцайдам сумын нутгаар 200 орчим тоо толгой бүхий халиун бугын сүрэг, 800 орчим тоо толгой бүхий цагаан зээрийн сүргийн нүүдлийн зам дайрч өнгөрдөг. Тус төслийн эцсийн миль

холболтийн 76км авто замын тендерээс өмнө төслийн талбай дээрх биологийн олон янз байдлын шинжилгээ, соёлын өвийн хээрийн судалгааг гүйцэтгэнэ. Биологийн олон янз байдлын судалгаагаар ямар нэгэн сөрөт нөлөөлөл тогтоогдвол, Биологийн олон янз байдлын цогц төлөвлөгөө (БОЯБЦТ)-г боловсруулан Угтаалцайдам, Цээл сумдыг холбох авто замын ажлын БОНМТ-г шинэчилнэ. Шаардлагатай бол, авто замын чиглэлийг өөрчлөх зэргээр нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг шинэчилсэн БОНМТ-д бас тусгана.

### Нийгэм-эдийн засаг

**Угтаалцайдам сүм** 1924 онд байгуулагдсан бөгөөд хүмүүс уг сумыг товчлон “Угтаал” гэдэг. Тус бус нутагт хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл хөгжсөн. Сумын төв байрлах Ар-Асгат нь 2276 хүн ам, 648 айл өрхтэй. Сумын газар нутгийн нийт талбай 154,800 га, түүнээс 103,000 га нь бэлчээр, 32,000 нь газар тариалан, 8,000 га нь ой, 1200 га нь хадлангийн талбай, 3200 га талбай нь зам ба бусад дэд бүтцийн байгууламжид хамаарна. Тус сумын малын тоо толгой 2017 оны байдлаар 126646 байв.

Жилд дунджаар 5,000-10,000 га талбайд үр тариа, 120-200 га талбайд төмс, хүнсний ногоо тариалдаг. Сумын айл өрхийн 85% нь төмс, хүнсний ногоо тарьж ургуулдаг. Хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагууд жилд 300-4500 тонн хадлан бэлтгэж дотоодын хэрэгцээгээ хангахаас гадна зах зээлд зарж борлуулдаг. Нийт 25 аж ахуйн нэгж, 68 хувь хүн 32,000 га газар эзэмшдэг.



**Цээл сүм** 1976 онд байгуулагдсан бөгөөд 1977 онд албан ёсоор бүртгэгджээ. Тус сумын суурьшигчид нь голдуу малчид, тариаланчид, хувь хүмүүс байна. Сумын хойд хэсгээр элсэргхэг газар нутаг байх ба “Элсэн цагаан” хэмээн нэрийднэ. Газар нутгийн 36000 га талбайг газар тариалан, 14400 га талбайг хадлан, 110000 га талбайг бэлчээр, 4500 га талбайг ойн бус нутаг эзэлнэ. Сумын нийт газар нутаг 165600 га. Сумын нийт хүн ам 2014 онд 2534 бөгөөд 729 айл өрхтэй хэмээн бүртгэгдсэн. Цээл сумд 2017 оны байдлаар 122600 толгой мал тоологдажээ.

### Ложистик ба уялдаа холбоо

Улаанбаатар хотоос Баянхангай сум хүртэл 100 км хатуу хучилттай замаар холбогдсон. Баянхангайгаас Угтаалцайдам хүртэл 45 км шороон замтай. Хур тунадас ихтэй үед шавар үүсч тээврийн хэрэгсэл гулган, хөдөлгөөнд аюул учирдаг бөгөөд заримдаа үерийн ус зам дээр хуримтлагдсаны улмаас гол замын хажуугаар түр зуурын олон салаа зам үүсгэн явдаг.

Одоогийн байдлаар Улаанбаатараас Угтаалцайдам хүрэх нийтийн тээвэр өдөрт нэг удаа зорчдог. Замын таагүй нөхцлөөс шалтгаалан тээврийн хэрэгсэл ойр ойрхон засвар үйлчилгээнд орох шаардлага тулгардаг. Угтаалцайдам, Цээл сумдад механик засварын үйлчилгээ байхгүй.

Угаалцайдам сүм дахь замын өнөөгийн нөхцөл байдал (Эх сурвалж: ТЭЗҮ-ийн талын Р2-39, MCPCgr ХХК):



Цээл сүм дахь замын өнөөгийн нөхцөл байдал (Эх сурвалж: ТЭЗҮ-ийн тайлан Р2-40, MCPCgr ХХК):





### Биет соёлын нөөц

2018 онд ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн судлаач А.Энхтөр, С.Далантай, Ц.Буянхишиг нар<sup>3</sup> Төв аймгийн Баянхангай, Угтаалцайдам, Цээл, Заамар сумдын хатуу хүчилтгүй, шороон зам дагуу явж, археологийн урьдчилсан судалгаа хийсэн байна. Үүний үр дүнд Угтаалцайдам, Цээл сумын шороон замын дагуу археологийн таван дурсгалт газар байгааг тогтоожээ. Дэлхийн Банкны санхүүжилтээр баригдах Угтаалцайдам сумын холбох замын төслийн тендер зарлашдахаас өмнө өв соёлын судалгааг зохион байгуулна. Дэлхийн Банкны санхүүжилтээр баригдах холбох замын чиглэлд ямарваа нэг соёлын өв байгаа нь тогтоогдвол тус холбох замын чиглэлийг өөрчлөх юм.

Тогтоогдсон археологийн дурсгалт газруудаас гадна, 2021 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр Цээл сумын иргэдтэй хийсэн цахим уулзалтаар “Аадгайн даваа” овоо нь шашны зан үйл, нутгийн ардын шүтлэгтэй холбоотой онцгой газар гэдгийг олж мэдсэн. “Аадгайн даваа” овооны эгц замыг аюулгүй байдлын үүднээс арай алсуур налуу болгож тавих хэрэгтэй гэдгийг багийн төлөөлөгч илэрхийлсэн.



Зураг 5 Эх сурвалж: Нарийвчилсан зураг төслийн тайлан, МСРС, 4-р нүүр (2018 он) Аадгайн давааны зураг (зүүн) Цээл сум (голд), Угтаалцайдам сум (баруун)

<sup>3</sup> Энэхүү БОНМТ-нд археологийн урьдчилсан судалгааны тайланг (Монгол хэлээр) хавсаргав.

### 3. Хууль ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН ХҮРЭЭНИЙ АЖИЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН ШААРДЛАГА

#### 3.1 Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний ажил

Дэлхийн Банкнаас гаргасан БОНМХ нь энэхүү төсөлд хамаарах бөгөөд уг төслийн хүрээнд байгаль орчин, нийгмийн стандартын хамаарлыг Хүснэгт 8-д нэгтгэн харуулав:

*Хүснэгт 2. БОНС-ын төслийн хамаарал*

№	Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС)	Хамааралтай эсэх	Шинжилгээ
1	БОНС1. Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ болон зохицуулалт	Хамаатай	Энэхүү стандартын дагуу Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ) төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлэх, удирдах, хянах үүрэгтэй.
2	БОНС2. Хөдөлмөр, ажлын нөхцөл	Хамаатай	Төсөлд зам барих, сэргээн засварлах ажилд орон нутгаас олон тооны барилгын ажилчдыг хамруулж байгаа тул БОНС2 үүнд хамааралтай гэж үзэж байна.
3	БОНС3. Нөөцийн үр ашиг болон, бохирдоос урьдчилан сэргийлэх	Хамаатай	Зам барилга, шинэчлэлийн ажил орон нутгийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл бага. Байгалийн нөөцийн хэрэглээ, хог хаягдал, барилгын явцад гарах утаа, ашиглалтын үе шат дахь амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл зэрэг нь шууд нөлөөлөлд хамаарна.
4	БОНС4. Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал	Хамаатай	Энэхүү стандарт нь төслийг хэрэгжүүлэх явцад орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг урьдчилан харах, сэргийлэх зорилготой. Газар шороо, замын ажлын цар хүрээ, шинж чанарыг харгалзан үзвэл уг төсөл нь ойр орчмын ард иргэдэд томоохон хүндрэл учруулахгүй, экосистемийн аливаа үйлчилгээнд нөлөөлөхгүй ба зам барих, сэргээн засварлах үед гарах дуу чимээ, тоосжилт, хог хаягдал, замын хөдөлгөөний эвдрэлийн түр зуурын болон орон нутгийн нөлөөллийг барилгын ажлын менежментийн сайн туршлагыг тусгаснаар бууруулж болно. Гэхдээ материалын эх үүсвэрээс гарах нөлөөллийг тендерийн шалгаруулалтыг эхлэхээс өмнө төсөл хэрэгжилтийн явцад гүйцэтгэнэ. Мөн Ковид-19 цар тахлын үед зам барих, сэргээн засварлахтай холбоотой ажиллах хүчний урсгалаас шаалтгаалан орон нутгийн иргэдийг өвчнөөс сэргийлэх зорилгоор холбогдох урьдчилан сэргийлэх арга хэмжээг төсөл хэрэгжүүлэх явцад авч хэрэгжүүлнэ.
5	БОНС5. Газар эзэмшил болон газар ашиглалт, албадан нүүлгэн шилжүүлэлтийг хязгаарлах	Хамаатай	Холбох зам барих ажилд газар чөлөөлөлтийн ажил гарахгүй. Орон нутгийн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор түр зуурын зам барих, материал бэлтгэх газар зэргийг байгуулна. Оролцогч талуудын үүрэг оролцооны төлөвлөгөө (OTYOT) нь холбох замаас орон нутгийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг багасгах зорилгоор оролцогч талуудыг тодорхойлох, татан оролцуулах тодорхой журам, алхмуудыг бэлтгэсэн.

6	БОНС6. Биологийн төрөл зүйлийг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент	Хамаатай	Энэхүү стандарт нь биологийн төрөл зүйл, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежментийг дэмжих зорилготой бөгөөд энэхүү стандартын дагуу төслийн үйл ажиллагаа нь биологийн төрөл зүйлд хор хөнөөл учруулж буй эсэх, орон нутгийн иргэдийн экосистемийн үйлчилгээнд нэвтрэх, ашиглахад саад учруулахгүй байх зэрэгт ЗХЯ-наас хяналт тавих шаардлагатай.
7	БОНС7. Нутгийн уламжлалт нийгэмшлээс алслагдсан уугуул иргэд/Африкийн өмнөд хэсгийн хүмүүс	Хамаатай	Төслийг батлахаас өмнө Увс гэх мэт аймагт амьдарч буй үнднсний цөөнхүүдтэй төслийн талаар зохих байдлаар тэдний соёлд нийцэхээр зөвшилцөх шаардлагатай тул энэхүү стандарт үүнд хамааралтай гэж үзэж байна.
8	БОНС8. Соёлын өв	Хамаатай	Төслийн бэлтгэлийн явцад гарсан загвар, байгаа мэдээлэл зэрэгт үндэслэн энэхүү стандартыг хамааралтай гэж үзсэн. Замын барилгын ажил, сэргээн засварлах ажлын явцад соёлын өвийг сүйтгэхгүй байх үүднээс санамсаргүй олдох журмыг хэрэгжүүлнэ. Зам барих, сэргээн засварлах явцад соёлын өвийг сүйтгэхгүй байх үүднээс санамсаргүй олдох журмыг хэрэгжүүлнэ.
9	БОНС9. Санхүүгийн зуучлагчид	Хамаарлын бус	ЗХЯ-аас уг төслийг хэрэгжүүлэх тул энэ стандарт нь хүлээгдэж буй төсөлд хамааралгүй юм. Мөн санхүүгийн зуучлагч оролцохгүй.
10	БОНС10. Хувь эзэмшигчдийн оролцоо, мэдээллийн ил тод байдал	Хамаатай	Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг сайжруулах боломжтой тул ЗХЯ-аас төслийн оролцогч талуудын ил тод, утга учиртай оролцооны ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байгаа болно. Энэхүү стандартын дагуу ЗХЯ нь оролцогч талууд болон төслийн нөлөөлөлд орсон талуудыг тодорхойлох, мөн бүх хугацаанд бүтээлч харилцааг бий болгох, хадгалахад чиглүүлэн, оролцогч талуудын оролцоонд системтэй хандлагыг бий болгох зорилготой Оролцогч талуудын үүрэг оролцооны төлөвлөгөөг боловсруулсан.

Түүнчлэн, Дэлхийн Банкны Группээс гаргасан Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын дараах удирдамжийг төсөлд хэрэглэх боломжтой гэж үзсэн. Тухайлбал:

- Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий удирдамж
- Төлбөртэй замд зориулсан байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамж
- ДБ-ны БОНМХ-ний замын аюулгүй байдлын тухай Сайн туршлагын баримт бичиг
- ДБ-ны холбогдох аж үйлдвэрлэлийн салбарын байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамж
- ДБ-ны БОНМХ/Түр хамгааллын баримт бичиг болон КОВИД-19 цар тахлаас урьчилан сэргийлэх ДЭМБ-ын удирдамж

### 3.2 Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулалт, стандарт

#### 3.2.1 Монгол Улсын байгаль орчны бодлого зохицуулалтын баримт бичгүүд

Монгол Улс байгаль орчны үнэлгээ, менежментийн цогц бодлого, эрх зүйн орчныг баталсан ба энэхүү цогц бодлого нь иргэдийн эруул мэнд, сайн сайхны төлөө хамгаалагдсан эзэмшил газрыг удирдах, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, байгаль орчны чанарыг хамгаалах бодлого, хууль тогтоомж, стратеги зэргийг багтаасан болно. Монгол Улсын байгаль орчны менежментийн бодлого, хууль тогтоомжийн шатлал нь Үндсэн хуулиас эхлээд олон улсын гэрээ, байгаль орчин, нөөц баялгийг хамгаалах хууль зэрэг таван үе шатаас бүрдэнэ. Бодлогын үндсэн баримт бичгүүдэд БОАЖЯ-ны ажлын хүрээнд боловсруулан баталсан 1995 оны Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө, 1997 оны Байгаль орчны талаар төрөөс баримтлах бодлого, Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны хөтөлбөр, Тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө, түүнчлэн Монгол Улсын 21-р зууны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг багтаж байна. Байгаль орчныг хамгаалах үндэсний хөтөлбөрийг 2000 онд шинэчлэн баталсан ба энэхүү хөтөлбөрт Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг мөн онд нэмж тусгасан. Эхний арван жилийн хугацаанд хэд хэдэн хөтөлбөрийн баримт бичгийг (жишээ нь Усны тухай үндэсний хөтөлбөр, Ойн үндэсний хөтөлбөр, Агаарыг хамгаалах хөтөлбөр, Байгаль орчны боловсрол, Тусгай хамгаалалттай газар нутаг, Озоны давхаргыг хамгаалах) боловсруулж дуусгасан. 1998 оноос Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний талаар төрөөс баримтлах бодлогыг мөрдөж эхэлсэн. Үүнээс гадна бусад яамдын ивээл дор байгаль орчинд нөлөөлөх бусад удирдамж бичиг баримтуудыг боловсруулсан бөгөөд үүнд Замын ерөнхий төлөвлөгөө, Эрчим хүчний салбарын ерөнхий төлөвлөгөө, Аялал жуулчлалын ерөнхий төлөвлөгөө, сэргээгдэх эрчим хүчний мастер төлөвлөгөө зэрэг багтаж байна. Жил бүрийн Хүний хөгжлийн тайлан зэрэг бусад баримт бичгүүдэд байгаль орчны асуудлууд улам бүр нэмэгдсээр байна. Монгол Улсын байгаль орчны төрөөс баримтлах бодлогын үндсэн зарчимд зааснаар эдийн засгийн хөгжил нь байгалийн баялгийн олборлолт, ашиглалттай уялдаж, агаар, ус, хөрсний бохирдлыг хянах явдал гэсэн байдаг. 1996 оны дөрөвдүгээр сард Монгол Улсын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийг тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зорилгоор байгуулсан. Харин Монгол Улсын стратеги нь байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд тогтвортой, нийгмийн баялгийг хөгжүүлэхэд чиглэгдэх бөгөөд энэ нь урт хугацааны тогтвортой хөгжлийг тодорхойлох замаар улс орны иргэнийг чухалчлан үзнэ.

Монгол Улсын Засгийн газар 1990, 2012 онуудад байгаль орчны тухай хуулид томоохон өөрчлөн шинэчлэл хийж газрын тухай, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, ус, ой, ан амьтан, унаган ургамлын нөөцийн тухай хууль тогтоомжуудыг батлуулсан. Хүснэгт 3-с харахад байгаль орчны үндсэн хууль тогтоомжийн цар хүрээ өргөн хүрээтэй байгааг харж болно.

*Хүснэгт 9 Байгаль орчны тухай гол хууль тогтоомжууд*

№	Зохицуулалт	Шаардлага	Төлөлд хамааралтай эсэх
1	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)	Зам барилга, засвар үйлчилгээ, дэд бүтэц байгуулах төслүүдэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж болно	Хамаатай
2	Байгаль хамгаалах тухай хууль (1995)	Нийгэм, эдийн засгийн хөгжил нь байгаль орчныг хамгаалах ажилтай тэнцвэржүүлэн хэрэгжүүлнэ	Хамаатай
3	Дархан цаазат газрын тухай хууль (1994)	Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний хамгаалалбүсэд тодорхой үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрнө	Хамаатай

4	Соёлын өвийн тухай хууль (2014)	Дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслийн хүрээнд соёлын биет болон биет бус өвийг томоохон хэмжээний газар шорооны ажил хийхээс өмнө судалж, хамгаална	Хамаатай
5	Хог хаягдлын тухай хууль (2017)	Хог хаягдаас үүсч болох нөлөөлөл, эрсдлийг тодорхойлж түүнийг бууруулах болон шаардлагатай арга хэмжээг авна	Хамаатай
6	Усны тухай хууль (2012)	Усны эх үүсвэрийг үр ашигтай ашиглаж удирдана	Хамаатай
7	Хөдөлмөрийн тухай хууль (1999)	Ажилчдын эрх, үүргийг хүндэтгэн үзэх ба тэднийг эрүүл, аюулгүй ажиллах нөхцлөөр хангана	Хамаатай
8	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008)	Энэхүү хууль болон шаардлагуудыг ажлын орчны бүх түвшинд хатуу чанд мөрдөнө	Хамаатай
9	Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль (2011)	Эрэгтэй, эмэгтэй бүх ажилтан, ажилчдыг тэгш боломж бололцоогоор хангана	Хамаатай
10	Авто замын тухай хууль (2017)	Зам барилга болон арчилааны ажил нь байгаль орчинд серөг нөлөөлөл үзүүлэхгүй	Хамаатай
11	МУ-ын Үндсэн Хууль (Өөрчлөлт 2019) (Зүйл 14.2)	Үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, өмч хөрөнгө, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор хэнийг ч ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй	Хамаатай
12	Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, 32, 37 дугаар зүйл	Шугам сүлжээ болон улсын эзэмшлийн бусад объектыг улсын тусгай хэрэгцээнд буцааж авах үед тэдгээрийг нийтийн хэрэгцээнд зориулан нөхөн төлбөр төлөх замаар буцаан авах эрх үүснэ	Хамаатай
13	Газрын тухай хууль		
14	Монгол Улсын иргэний хууль бол төслийн нөлөөнд өртөж байгаа ААН-ээс авхуулаад төрийн өмчийн хамгаалалтын зурvas дахь газар шилжүүлэх гэрээ хэлэлцээрийн хууль эрх зүйн үндэс болно (15 дугаар бүлэг дэх 1, 6, 7, 8, 109,112 дугаар заалт болон бусад зүйлд)	Төлбөр тооцооны зохицуулалтыг авч хэлэлцсэн	Хамаатай
15	Соёлын тухай хууль (1.3, 19.2 зүйл)	Соёлын өвийг хамгаалж угсаатны соёлыг ялгаварлан гадуурхах, дарамт учруулахыг хориглоно	Хамаатай
16	Хөдөлмөрийн тухай хууль (7.1 зүйл)	Үндэстэн хоорондын тэгш байдлыг хангана	Хамаатай
17	Эрүүгийн хууль (2.14, 14.1 зүйл)	2.14.үзэл бодол, арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхах сэдэл нь арван хоёр жилээс хорин хоёр хүртэлх жил, эсвэл бүх насаар хорих ялаар шийтгэх үндэс байж болно. 14.1. Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, өмч хөрөнгө, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн чиг хандлага, хүйс, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхах, эрх, эрх	Хамаатай

		чөлөөг хязгаарлах нь дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсвэл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсвэл нэг сараас нэг жил хүртэлх хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах шийтгэх үндэс болно.	
--	--	---	--

Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний (БОНБҮ) тавигдах шаардлагыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар (2012) зохицуулдаг. Энэхүү хууль нь байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх, байгалийн нөөц ашиглалтын улмаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ, бус нутгийн болон салбарын бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл зэргийг зохицуулах зорилготой болно. БОНБҮ-г зөвхөн Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж явуулах боломжтой бөгөөд тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын жагсаалтыг БОАЖЯ-ны вэбсайтад байршуулсан болно.

Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулинд зааснаар хоёр төрлийн үнэлгээ байна:

(i)      БОНБ өрөнхий үнэлгээ (танилцуулга) - Ерөнхий БОНБҮ-г эхлүүлэхийн тулд төсөл хэрэгжүүлэгч нь ТЭЗҮ, техникийн дэлгэрэнгүй мэдээлэл, зураг төсөл болон бусад мэдээллийн тухай төслийн товч танилцуулгыг БОАЖЯ (эсвэл аймгийн засаг захиргаа)-д хүргүүлнэ. Ерөнхий БОНБҮ нь дараах дөрвөн дүгнэлтийн аль нэгээр гаргаж болно: (i) нарийвчилсан БОНБҮ шаардлагагүй, (ii) төслийг тодорхой нөхцлийн дагуу дуусгах, (iii) нарийвчилсан БОНБҮ шаардлагатай байх, эсвэл (iv) төслийг цуцлах. Ерөнхий БОНБҮ нь үнэ төлбөргүй бөгөөд ихэвчлэн ажлын 14 хүртэл хоног зарцуулдаг.

(ii)      Нарийвчилсан БОНБҮ – Үүний хамрах хүрээг өрөнхий БОНБҮ-ээр тодорхойлно. БОНБҮ-ний нарийвчилсан тайланг тусгай журмын дагуу БОАЖЯ-наас зөвшөөрөл авсан Монголын компани гаргах ёстой. Нарийвчилсан БОНБҮ-г боловсруулагч нь БОАЖЯ-нд (эсвэл аймгийн засаг захиргаа) хүргүүлнэ. Ерөнхий БОНБҮ-г явуулахад оролцсон байгууллагын мэргэжилтэн нарийвчилсан БОНБҮ-г 18 хоногийн дотор хянаж, БОАЖЯ-нд (эсвэл аймгийн засаг захиргаа) танилцуулна. Шинжээчдийн дүгнэлтийг үндэслэн БОАЖЯ (эсвэл аймгийн засаг захиргаа) төслийг батлах эсвэл зөвшөөрөхгүй байх шийдвэр гаргана.

(iii)      Нарийвчилсан БОНБҮ нь дараах бүлгүүдийг агуулсан байх ёстой: (i) Байгаль орчны суурь мэдээлэл; (ii) Төслийн хувилбарууд; (iii) нөлөөллийг багасгах, бууруулах, арилгах зөвлөмж; (iv) Сөрөг нөлөөлөл, тэдгээрийн үр дагаврын цар хүрээ, тархалтын дүн шинжилгээ; (v) Эрсдлийн үнэлгээ; (vi) Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө; (vii) Байгаль орчны мониторингийн хөтөлбөр; (viii) Төслийг хэрэгжүүлэх эсэх талаар оршин суугчдын санал

Төлөвлөж буй үйл ажиллагааны байршил, төрөл, хэмжээ нь БОАЖЯ эсвэл орон нутгийн захиргаа БОНБҮ-г хэрэгжүүлэх хийх үүрэг хариуцлагыг тодорхойлно. Монгол Улсын тээврийн холболт, ложистикийг сайжруулах төсөлд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа нь үндэсний хуулийн эдгээр шаардлагыг сэргээх магадлалтай гэж үзэж байна.

Угаалцайдам, Цээл сумдыг холбох авто замыг барихад БОННҮ<sup>4</sup>-г гүйцэтгэх шаардлагатай. БОАЖЯ-наас байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг гүйцэтгэхэд байгаль орчны суурь судалгаа, техник эдийн засгийн үндэслэлийн судалгааны тайлан болон бусад баримт бичгүүд<sup>5</sup>-ийг шаарддаг бөгөөд ерөнхий үнэлгээгээр БОННҮ-г гүйцэтгэхийг шаардах магадлалтай юм.

Байгаль орчны мониторингийн суурь үзүүлэлтийг бий болгох нь орчны агаар, ус, дуу чимээ, хөрсний чанарын чиг хандлагыг тодорхойлох, бохирдуулагч бодис ялгараах, хүний үйл ажиллагааны бусад үйл ажиллагаа болон/эсвэл хог хаягдлыг боловсруулах үйл ажиллагаа (нөлөөлөл) энэ чанарт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход оршино (нөлөөллийн мониторинг). Агаар мандал, гүний ус, нуур эсвэл төслийн хүрээнд болон ойр орчмын нутаг дэвсгэрт хаягдаж буй шим тэжээлийн бодис, бохирдуулагч бодисын урсгалыг тооцоолохын тулд байгаль орчны мониторинг хийх шаардлагатай. Төсөлтэй холбоотой аливаа төрлийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө хүрээлэн буй орчны чанарыг тодорхойлох зорилгоор хяналт шинжилгээ хийдэг бөгөөд энэ нь нөлөөллийн хяналттай харьцуулах арга хэрэгсэл болдог. Үүнийг мөн онгон зэрлэг нөхцөлд гэнэтийн өөрчлөлт гарсан эсэхийг шалгахад ашиглах боломжтой.

Ус, цаг уур, орчны шинжилгээний газар нь ус, агаар, хүчиллэгийн хуримтлал, хөрс, хүрээлэн буй орчны цацраг, тоосжилт, хүхрийн хийн зэрэгт хүрээлэн буй орчны хяналт шинжилгээг хийж, байгаль орчны чанарыг хянах үүрэгтэй. Томоохон хотуудын лабораториуд агаар, ус, хөрсний чанар, цацрагийн түвшинг тогтмол хэмждэг бөгөөд үүний зэрэгцээ цахилгаан станц, тээврийн хэрэгслийн бохирдлын эх үүсвэрийг хянах; байгаль орчны үнэлгээнд шаардлагатай мониторингийн үйл ажиллагааг явуулах; байгаль орчныг хянадаг бусад байгууллагуудтай хамтран үйлдвэрлэлийн хог хаягдлыг хянах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

### 3.3 Монгол Улсын хууль тогтоомж, Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн стандартуудын хоорондын зөрүүнд хийсэн шинжилгээ

Монголын талаас болон ДБ-наас гаргасан байгаль орчин, нийгмийн шаардлагуудын хооронд тодорхой зөрүү байгаа бөгөөд эдгээр ялгаатай талуудад хийсэн дүн шинжилгээний гол хэсгүүдийг Хүснэгт 4-т үзүүлэв.

*Хүснэгт 10 Байгаль орчны болон нийгмийн бодлогын хоорондын зөрүүтэй байдалд хийсэн шинжилгээ*

Сэдэв	Илэрсэн зөрүү (ДБ-наас гаргасан заалтууд)	Зөрүүг арилгах арга хэмжээ
Байгаль орчны хамрах хүрээ	Монгол Улсын БОНБҮ-ний тухай хууль нь зөвхөн хүний эрүүл мэнд, байгаль орчны тухай заасан байдаг (ДБ-ны ESF ESS1)	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь байгаль орчин, хөдөлмөрийн нөхцөл, хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, нөөцийн үр ашиг ба тогтвортой менежмент, албадан нүүлгэн шилжүүлэлт, уугуул иргэд, соёлын өв, хил дамнасан болон дэлхийн байгаль орчны аливаа асуудлыг багтаасан БОНБ-д тодорхойлсон бүх асуудлыг багтаавал зохино. Бүх дэд төслүүдийг үнэлнэ.
	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын бүсэд зөвхөн тодорхой төрлийн үйл	Бүх дэд төслүүдийг үнэлэх шаардлагатай.

<sup>4</sup> БОННҮ-г зөвхөн БОАЖЯ-ны цахим хуудас дээр байршуулсан тусгай зөвшөөрөл бүхий этгээд гүйцэтгэнэ.

<sup>5</sup> Дараах цахим хуудаснаас байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнд шаардлагатай баримт бичгүүдийг үзнэ үү. <https://e-mongolia.mn/service/baigali-orchny-nuluulliin-yerunkhii-unelgeenii-dugnelt->

	ажиллагаа нь БОНБҮ-д хамрагдана (ДБ-ын ESF ESS1)	
Хөдөлмөрийн нөхцөл болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	<p>Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008) нь ОУХБ-ын хөдөлмөрийн үндсэн стандартыг хэрэгжүүлж, ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах эрх, үүргийг тогтоосон.</p> <p>Гэсэн хэдий ч үндэсний хууль тогтоомж нь бүх ажил олгогчдод үйлчилдэг тул туслан гүйцэтгэгчид хөдөлмөр, ХАБЭА-н шаардлагыг хангасан байх хуулийн үүрэг байхгүй. ХАБЭА-тай холбоотой эрсдлийг бууруулах тусгай арга хэмжээг үндэсний хууль тогтоомжид заагаагүй ч заримыг нь үндэсний стандарт, дүрэм журмаар тогтоосон байдаг. (ДБ ESF ESS2)</p>	<p>БОНМХ-нд туслан гүйцэтгэгчид хөдөлмөр болон ХАБЭА-н ижил шаардлагад хамрагдах, мөн дэд төслийн БОНМХ-нд сөрөг нөлөөллийг бууруулах зохих хувилбаруудыг боловсруулсан эсэхийг баталгаажуулах заалтуудыг агуулна.</p> <p>Мөн Хөдөлмөрийн Удирдлагын журмыг боловсруулсан.</p>
Нөөцийн үр ашиг, бохирдлын хяналт	<p>Монгол Улсын агаарын тухай, усны тухай, хог хаягдлын тухай хуулиудад нөөцтэй холбоотой ерөнхий шаардлагыг тодорхойлсон байдаг. Гэсэн хэдий ч аливаа эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой бохирдлын хяналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхой зааж өгөөгүй байна. (ДБ ESF ESS3)</p> <p>Дотоодын хууль тогтоомжинд нөөцийн үр ашгийг хангах ямар нэгэн эрх зүйн шаардлага тусгагдаагүй байна. (ДБ ESF ESS3)</p>	<p>Дэд төслийн байгаль орчны шалгалтын үйл явц нь БОНМХ-тай холбоотой гол асуудлуудыг тодорхойлох бөгөөд БОНМХ нь Дэлхийн Банкны Группийн холбогдох баримт бичгүүдийг багтаасан Олон улсын аж үйлдвэрийн сайн туршлагыг иш татан нөөцийн үр ашиг, бохирдлын менежментийн удирдамжийг боловсруулсан болно.</p>
Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал	Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар тусгайлсан хууль байхгүй. (ДБ ESF ESS4)	<p>БОНМХ нь орон нутгийн иргэдэд төслийн хөндлөнгийн оролцоо, ажлын байр, орон нутагт COVID-19 тархахаас үүдэлтэй эрүүл мэнд, аюулгүй байдал, аюулгүй байдлын эрсдэл, нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах зааварчилгааг өгсөн. Хортон шавьж, замын хөдөлгөөний болон замын аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал зэрэг нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээг энэхүү баримт бичигт тодорхойлсон болно.</p>
Албадан нүүлгэн шилжүүлэлт	Монгол Улсад газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх тухай хууль байхгүй. Монгол Улсын Газрын тухай хуульд тодорхой ангиллын газар өмчлөх, эзэмших эрхийг	<p>Зам барих зориулалтаар газар чөлөөлөх, газрын эрхийн өөрчлөлттэй холбоотой аливаа үйл ажиллагааг төслөөс санхүүжүүлэхгүй гэж ЗТХЯ-аас мэдэгдсэн. Гэсэн хэдий ч холбо зам</p>

	<p>тодорхойлж, сумын Засаг дарга нар малчдын бүлэгтэй газар ашиглах гэрээ байгуулах боломжийг олгодог. Сумын Засаг даргаас өргөн мэдүүлсэн, орон нутгийн газрыг өөр өөр зориулалтаар ашиглах тухай төрөл бүрийн хүсэлтийг тусгасан сумын жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах, татгалзах эрхтэй бөгөөд төслийг хэрэгжүүлэх явцад энэхүү журмыг баримтална.</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутаг, орчны бүсэд бэлчээр ашиглаж буй малчдын дийлэнх нь албан ёсоор өмчлөгдсөн газрын эрхгүй ч зарим нь өвөлжөө хаваржааны зориулалтаар хязгаарлагдмал хугацаагаар ашиглах гэрээтэй байж болно. Газар зохион байгуулалтын төлөвлөлтөд газар ашиглалтыг авч үзэх ёстой гэж үздэг боловч үндэсний хууль тогтоомжид заншлын эрх нь албан ёсны статусгүй байдаг. Монгол Улсад нийтийн эзэмшилийн газрыг төрийн өмчид шилжүүлэн авах тухай хууль байхгүй. Дэлхийн банкны стандартын дагуу нийтийн зайлшгүй хэрэгцээнд газар чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулсан ч хараахан батлагдаагүй байна. Хэрэв хууль батлагдвал БОНБҮТ-ийг шинэчлэх шаардлагатай болно. (ДБ ESF ESS5)</p>	<p>барих явцад материал нийлүүлэх, түр газар ашиглах зэргээс шалтгаалан газрын хүртээмжийг хязгаарласнаас үүдэн амьжиргаанд нөлөөлөх төлөвтэй байгаа ба ДБГ-ын БОНСБ хэрэгжинэ. Газар ашиглалтаас амьжиргаанд үзүүлэх нөлөөлөлөөс зайлсхийх боломжгүй тохиолдолд нөлөөллийн үнэлгээ, Нуулгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцыг удирдан чиглүүлэх RPF бэлтгэсэн.</p>
Биологийн төрөл зүйл ба нөөцийн тогтвортой менежмент	<p>Монгол Улсад амьтан хамгаалах, тогтвортой мал аж ахуйн салбарын тухай хууль байхгүй. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль байдаг ч өөрчлөгдсөн, энэ хууль байгалийн болон чухал биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг тусгайлан заагаагүй. (ДБ ESF ESS6)</p>	<p>БОНМХ нь Дэлхийн Банкны Группийн холбогдох БОНБҮ-г багтаасан GIIP-д тулгуурлан удирдамж боловсруулсан. Түүнчлэн амьтны амьдрах орчинд үзүүлэх аливаа серег нөлөөллөөс зайлсхийх зорилгоор хасах шалгуурыг БОНБҮ-нд оруулсан болно.</p>
Үүгүүл иргэд	<p>Монгол Улсын Үндсэн хуульд “Үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, эд хөрөнгө, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заасан байдаг. Гэсэн хэдий ч үндэсний цөөнхийн талаар өөр тусгайлсан</p>	<p>Уг төсөл нь үндэстний цөөнх оршин суудаг бүс нутагт үнэ төлбөргүй, урьдчилан мэдээлэл өгөх замаар тэднийг төслийн үйл ажиллагаанд хамруулах боломжийг судална. Үндэстний цөөнхийн булгүүдтэй зөвшилцэхдөө үндэстний цөөнхөд тохирсон арга барилаар, жишээлбэл, тэдний хэлийг ашиглах замаар.</p>

	хууль тогтоомж байхгүй. Үндэсний боловсрол, хэлний бодлого нь ерөнхийдөө монгол хэлийг дэмжих хандлагатай байсан бөгөөд халх монгол хэл нь төрийн албан ёсны хэл юм. (ДБ ESF ESS7)	
Соёлын өв	Соёлын өвтэй холбогдох хуулиудад Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Соёлын өвийн тухай хууль багтана. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөр өөр статустай улсын тусгай хамгаалалттай газар нутагт өөр өөр бүсэд зөвшөөрөгдсөн болон хориглосон үйл ажиллагаа явуулах, газар ашиглах зөвшөөрөл олгоход төрийн янз бүрийн шатны байгууллагын үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байдаг. Соёлын өвийн тухай хуулиар биет өвийг бүртгэх ажлыг эхлүүлж, биет өвийг хамгаалах үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгсөн. (ДБ ESF ESS8)	Төсөл нь соёлын өвийг тодорхойлох, бүртгэх, хамгаалахад оролцогч талуудын оролцоог дэмжинэ. Соёлын өвд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа үйл ажиллагаа төслийн санхүүжилтэд хамрагдах боломжгүй болно. Мөн БОНМХ-т боломж олдох журмыг багтаана.
Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ дэх олон нийтийн оролцоо	БОНHY-ний тухай хуульд зааснаар БОНЕY-ний ажилд олон нийтийн оролцоо шаардлагагүй болно (ДБ ESF ESS1, ESS10)	БОНHY нь гол оролцогч талуудтай утга зорилго бүхий зөвлөлдөж, тэдний санал бодлыг харгалзан үзсэн эсэхийг баталгаажуулна.
	БОНHY-д олон нийтийн оролцооны тухай журам нь зөвхөн олон нийтийн оролцооны талаарх ерөнхий удирдамжийг гаргасан (ДБ-ын ESF ESS10)	БОНHY нь гол оролцогч талуудтай утга зорилго бүхий зөвлөлдөж, тэдний санал бодлыг харгалзан үзсэн эсэхийг баталгаажуулна.
Олон нийтэд мэдээлэх, ил болгох	БОНY-ний тухай хуулийн олон нийтэд мэдээлэх, ил тод болгох тухай заалт хангалтгүй байна (ДБ ESF ESS10)	БОНМХ болон байгаль орчин нийгмийн удирдлагын төлөвлөгөөний дэд төслүүд нь олон улсын стандартад нийцүүлэн төслийн төлөвлөгөө, БОНHY-г олон нийтэд мэдээлэх, ил тод болгох журмыг тодорхойлсон.
Мэдээлэл	БОНY-ний тухай хуульд зөвхөн БОНHY-ийн дагуу БОМТ-ийн талаар тайлагнахыг шаарддаг (ДБ-ын ESF ESS1, ESS10)	Байгаль орчин, нийгмийн бүхий л баримт бичгийн төлөв байдал, мониторингийн үр дүнг бүх оролцогч талуудад мэдээнэ. .

### Монгол Улсын байгаль орчны стандартууд

MNS дугаар	Монгол Улсын үндэсний стандартын нэршил (MNS)
MNS 17.5.13. 1980.	Байгаль хамгаалал. Эвдэrsэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо. Тодорхойлолт
MNS 5914:2008.	Байгаль хамгаалал. Эвдэrsэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо. Тодорхойлолт
MNS 5915:2008.	Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажилгаагаар эвдэrsэн газрын ангилал
MNS 5916:2008.	Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс

	хуулалт , хадгалалт
<b>MNS 5917:2008.</b>	Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
<b>MNS 5918:2008.</b>	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
<b>MNS 4191:1993.</b>	Байгаль орчныг хамгаалах стандартын систем. Монгол орны уур амьсгал үндсэн үзүүлэлт
<b>MNS 4585:2016.</b>	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
<b>MNS 4991:2000.</b>	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын бүсийн агаар дахь хорт бодисын концентрацыг хэмжих аргачлалд тавих шаардлага
<b>MNS 5885:2008.</b>	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
<b>MNS 3384:1982.</b>	Агаар мандлаас сорьц авахад тавих ерөнхий болон тенхикийн шаардлага
<b>MNS 6063:2010.</b>	Агаарын чанар - Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ
<b>MNS 5803:2007.</b>	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хар тугалгын агууламж, ажлын байранд тавигдах шаардлага
<b>MNS 3383:1982.</b>	Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нэр томъёо тодорхойлолт
<b>MNS 17.2.1.01:1978.</b>	Агаар мандал. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах агаар мандлыг бохирдуулах хорт бодис. Нэр томъёо, тодорхойлолт
<b>MNS 3113:1981.</b>	Агаар мандал. Агаарыг бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавих ерөнхий шаардлага
<b>MNS 5013:2009.</b>	Бензин хөдөлгүүртэй автомашин – утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
<b>MNS 5014:2009.</b>	Дизель хөдөлгүүртэй автомашин - Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
<b>MNS 5010:2001.</b>	Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага
<b>MNS 17.1.1.10:1979.</b>	Ус. Усны ашиглалт болон хамгаалалт. Нэр томъёо, тодорхойлолт
<b>MNS 17.1.1.14:1980.</b>	Усан мандал. Ус ашиглалтын ангилал. Ерөнхий шаардлага
<b>MNS 4047:1988.</b>	Усан мандал. Гадаргын усны чанарыг хянах журам
<b>MNS 4586:1998.</b>	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
<b>MNS ISO 5667-14:2000.</b>	Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж
<b>MNS ISO 5667-3:1999.</b>	Усны чанар. Дээж авах 3-р хэсэг: Дээжийг боловсруулах ба хадгалах зөвлөмж
<b>MNS 3342:1982.</b>	Байгаль орчны хамгаалал, усан мандал. Газрын доорх усыг бохирдооос хамгаалах ерөнхий шаардлага
<b>MNS ISO 5667-11:2000.</b>	Усны чанар-Дээж авах: 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж
<b>MNS ISO 5667-4:2001.</b>	Байгаль орчин. Усны чанар. Дээжлэлт, 4-р хэсэг: Байгалийн болон хиймэл нуураас дээж авах заавар
<b>MNS ISO 5667-6:2001.</b>	Байгаль орчин. Усны чанар. Дээжлэлт. 6-р хэсэг: Гол, горхины уснаас дээж авах заавар
<b>MNS 6148:2010.</b>	Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
<b>MNS 0900:2005.</b>	Үндны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
<b>MNS ISO 5667-5:2001.</b>	Байгаль орчин. Усны чанар. Дээж авах. 5-р хэсэг: Ундны ус, хүнс болон ундаа үйлдвэрлэхэд хэрэглэгдэх уснаас дээж авах заавар
<b>MNS 2573:1978.</b>	Усан мандал. Усны чанарын үзүүлэлт
<b>MNS 4943:2015.</b>	Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
<b>MNS ISO 5667-10:2001.</b>	Байгаль орчин. Усны чанар. Дээжлэлт. 10-р хэсэг: Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж
<b>MNS 6230:2010.</b>	Бохир ус зайлцуулах цэг тогтоох. Ерөнхий шаардлага
<b>MNS 5924:2015.</b>	Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага
<b>MNS 3474:2003.</b>	Ургамал хамгаалал. Нэр томъёо, тодорхойлолт
<b>MNS 3475:2003.</b>	Ургамлын хорио цээр. Нэр томъёо, тодорхойлолт
<b>MNS ISO 11269-1:2002.</b>	Хөрсний чанар. Хөрсний ургамал бохирдуулагч бодисын нөлөөллийг тодорхойлох арга. 1-р хэсэг: Ургамлын үндэсний өсөлт зогсолтыг хэмжих арга

<b>MNS ISO 11269-2:2013.</b>	Хөрсний чанар – Хөрс бохирдуулагчаас ургамалд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох туршилт. 2-р хэсэг: Бохирдсон хөрснөөс дээд ургамлын соёололт ба эрт ургалтад үзүүлэх нөлөөлөл
<b>MNS 5850:2008.</b>	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
<b>MNS 3297:1991.</b>	Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
<b>MNS 3298:1991.</b>	Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
<b>MNS 3985:1987.</b>	Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтүүд
<b>MNS 2305:1994.</b>	Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам
<b>MNS 5546:2005.</b>	Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага
<b>MNS 4968:2000.</b>	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн ўйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага /General requirements for production processes - Үйлдвэрлэлийн явцад тавигдах ерөнхий шаардлагууд*/.
<b>MNS 4930:2000.</b>	Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлагууд
<b>MNS 4969:2000.</b>	Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм
<b>MNS 4643:1998.</b>	Хөдөлмөр хамгаалал. Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө
<b>MNS 4994:2000.</b>	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага
<b>MNS 4994:2000.</b>	Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага
<b>MNS 5029:2011.</b>	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг
<b>MNS 5079:2001.</b>	Ачих, буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
<b>MNS 5105:2001.</b>	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага
<b>MNS 5146:2002.</b>	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй байдал Хамгаалах газардуулга, тэлэлт
<b>MNS 5150:2002.</b>	Цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага
<b>MNS 5145:2002.</b>	Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хүрэх хүчдэл ба гүйдлийн зөвшөөрөх дээд түвшин
<b>MNS 5149:2002.</b>	Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн давтамжтай цахилгаан орон. Ажлын байрны хүчлэгийн зөвшөөрөх түвшин
<b>MNS 0012.4.005:1985.</b>	Шуугианаас хамгаалах төхөөрөмж болон арга хэрэгсэл
<b>MNS 5003:2000.</b>	Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага
<b>MNS 5002:2000.</b>	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага
<b>MNS 12.1.016:1988.</b>	Хэт өндөр дуу. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
<b>MNS 4990:2015.</b>	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
<b>MNS 4931:2000.</b>	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага. Ерөнхий шаардлага, ангилал
<b>MNS 5621:2006.</b>	Толгой хамгаалах хэрэгсэл-Дуулга
<b>MNS 5388:2004.</b>	Толгой хамгаалах хэрэгсэл-сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл (бөглөө. чихэвч)-техникийн ерөнхий шаардлага
<b>MNS 5389:2004.</b>	Толгой хамгаалах хэрэгсэл-Нүд хамгаалах хэрэгсэл-Нүдний шил. Техникийн ерөнхий шаардлага
<b>MNS 5620:2006.</b>	Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл. (Хошуувч, шүүлтүүртэй баг, тусгаарласан агаартай бүтэн баг)
<b>MNS 5622:2011.</b>	Хамгаалалтын бээлий. Ерөнхий шаардлага
<b>MNS 5623:2006.</b>	Хөлний хамгаалалт Ажлын тусгай гутал
<b>MNS 5566:2005.</b>	Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гол унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
<b>MNS 4244:1994.</b>	Галын аюулгүй байдал Ерөнхий шаардлага

<b>MNS 5390:2004.</b>	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
<b>MNS 5344:2011.</b>	Ахуйн хог хаягдлын тээвэрлэлт. Ангилал. Ерөнхий шаардлага
<b>MNS 5282:2003.</b>	Газрын тосны бүтээгдэхүүний галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
<b>MNS 3629:1983.</b>	Нефть, нефтийн бүтээгдэхүүн. Савлах, хаяглах, тээвэрлэх
<b>MNS 4628:2013.</b>	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага
<b>MNS 4596:2014.</b>	Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм
<b>MNS 5342:2007.</b>	Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага
<b>MNS 4597:2014.</b>	Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага
<b>MNS 6515:2015.</b>	Тал хээр, говь цэлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага
<b>MNS 5645:2006.</b>	Барилгын ширхэгийн ба нурмаг ачаа тээвэрлэлт. Ангилал, Тээвэрлэлтийн нөхцөл, Ерөнхий шаардлага
<b>MNS 12.3.004:1983.</b>	Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар үйлчилгээ. Аюулгүй байдлын ерөнхий шаардлага
<b>MNS 4598:2011.</b>	Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага
<b>MNS 4601:2011.</b>	Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт

Монгол улсын үндэсний стандартууд нь орчны агаар, дуу чимээ, ус, хөрсний чанар, үйлдвэрлэлийн бохир ус, бохир ус, уурын зуухны ялгаруулалт гэх мэт зөвшөөрөгдхөн орчны болон гадагшлуулах стандартыг тогтооно. Холбогдох үндэсний стандартуудын талаар доор авч үзэв.

## Ус

Дараах хүснэгтэд Монгол улсын орчны усны чанарын стандарт MNS 4585: 2007, Монгол улсын үндны усны стандарт MNS 0900: 2005, бохир усны чанарын стандарт MNS 4943: 2011 зэргийг нэгтгэн харуулав. Байгаль орчны аюулгүй байдлын удирдамжид зааснаар технологийн бохир ус, ариун цэврийн байгууламжийн бохир ус, гадаргаас гарсан ус бохир ус зэргийн бохирдуулагчийн агууламж дотоодын усны чанарын зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэх ёсгүй. Ус болон хаягдал усны талаар Монгол Улсын үндэсний стандартыг ДЭМБ-ын Ундны усны чанарын удирдамжийн дөрөв дэх хэвлэлээр (2011) дэмжин энэхүү илтгэлд ашиглахаар баталсан.

Монгол улсын орчны усны чанарын стандарт (MNS 4585: 2007).

Хэмжүүр	Нэгж	Стандарт
(pH)		6.5-8.5
Усан дахь хүчилтөрөгчийн хэмжээ (O2)	Mg O/l	6&4-с багагүй
Биохимийн хүчилтөрөгчийн хэрэгцээ (BOD5)	Mg O/l	3
Химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ (COD)	Mg O/l	10
Аммонийн азот (NH4-N)	Mg N/l	0.5
Нитрит-азот (NO2-N)	Mg N/l	0.02
Нитрит-азот (NO3-N)	Mg N/l	9

Фосфат (PO <sub>4</sub> - P)	Мг Р/л	0.1
Хлор (Cl)	Мг/л	300
Фтор (F)	Мг/л	1.2
Сульфат (SO <sub>4</sub> )	Мг/л	100
Мангани (Mn)	Мг/л	0.1
Никель (Ni)	Мг/л	0.01
Зэс (Cu)	Мг/л	0.01
Молибден (Mo)	Мг/л	0.25
Кадми (Cd)	Мг/л	0.005
Кобальт (Co)	Мг/л	0.01
Хар тугалга (Pb)	Мг/л	0.01
Хүнцэл (As)	Мг/л	0.01
Нийт хром (Cr)	Мг/л	0.05
Зургаан валентын хром (Cr <sup>6+</sup> )	Мг/л	0.01
Цайр (Zn)	Мг/л	0.01
Мөнгөн ус (Hg)	Мг/л	0.1
Ашигт малтмалын тос	Мг/л	0.05
Фенол	Мг/л	0.001

Эх сурвалж: Монгол Улсын стандарт MNS 4586:1998.

Монгол Улсын үндны усны стандарт (MNS 0900: 2005).

Хэмжүүр	Нэгж	Стандарт
<b>Физик шинж чанар</b>		
pH	mg/l (milligrams/liter)	6.5-8.5
Хатуулаг	Мг эквивалент /л	7.0
Нийт ууссан хатуу бодис (TDS)	Мг/л	1000.0
Булингар	Мг/л	1.5
Амт	Оноо	2.0
Үнэр	Оноо	2.0
Өнгө	Зэрэг	20
<b>Органик бус чанар</b>		
Молибден (Mo)	Мг/л	0.07
Бари (Ba)	Мг/л	0.7
Бор (B)	Мг/л	0.5
Зэс (Cu)	Мг/л	1.0
Кальц (Ca <sup>2+</sup> )	Мг/л	100.0
Магнези (Mg <sup>2+</sup> )	Мг/л	30.0
Мангани (Mn)	Мг/л	0.1
Натри (Na)	Мг/л	200.0
Фосфат (PO <sub>4</sub> -)	Мг/л	3.5

Фтор (F)	Мг/л	0.7-1.5
Селени (Se)	Мг/л	0.01
Стронций (Sr)	Мг/л	2.0
Сульфат (SO <sub>4</sub> -)	Мг/л	500.0
Хлор (Cl)	Мг/л	350.0
Хүнцэл (As)	Мг/л	0.01
Устөрөгчийн сульфид (H <sub>2</sub> S)	Мг/л	0.1
Хром (Cr)	Мг/л	0.05
Хуурай тунадас	Мг/л	1000.0
Уран (U)	Мг/л	0.015
Бериллий (Be)	Мг/л	0.0002
Кадми (Cd)	Мг/л	0.003
Нийт мөнгөн ус (Hg)	Мг/л	0.001
Нийт цианид (CN-)	Мг/л	0.01
Аммонийн ион, (NH <sub>4</sub> +)	Мг/л	1.5
Нитратын ион (NO <sub>3</sub> -)	Мг/л	50.0
Нитритийн ион (NO <sub>2</sub> -)	Мг/л	1.0
Фосфатын ион (PO <sub>4</sub> -)	Мг/л	3.5
Мөнгө (Ag)	Мг/л	0.1
Иод (I <sub>2</sub> )	Мг/л	1.0
Винил хлорид	Мг/л	0.0003
Никель (Ni)	Мг/л	0.02
Хар тугалга (Pb)	Мг/л	0.01
Хөнгөн цагаан	Мг/л	0.5
Сурьма (Sb)	Мг/л	0.02
Нийт ион (Fe)	Мг/л	0.3
Цайр (Zn)	Мг/л	5.0
Органик шинж чанар		
Бензол	Мг/л	0.01
Ксиолууд	Мг/л	0.5
Нитрил 3 цууны хүчил	Мг/л	0.2
2 хлоржуулсан метан	Мг/л	0.02
2 хлоржуулсан этан	Мг/л	0.03
3 хлоржуулсан этан	Мг/л	0.07
4 хлоржуулсан этан	Мг/л	0.04
Фенолын нэгдлүүд	Мг/л	0.002
Стирол	Мг/л	0.02
Толуол	Мг/л	0.7
Этил бензол	Мг/л	0.3
Пестицид (хортон шавьж устгагч)		
Атразин	Мг/л	0.002
Карбофуран	Мг/л	0.007
Линдан	Мг/л	0.002
Молинат	Мг/л	0.006
Эндрин	Мг/л	0.00006
Микробын чанар		
Нийт колиформ	Савханцар/ml	100 (эх үүсвэр дээр) 20 (нийлүүлэлт)
Эскерих савханцар	E.савханцар/ 100 ml	E.савханцар / 100 ml
Цацрагийн чанар		

Нийт α цацраг идэвхи	Бк/л	0.1
Нийт β цацраг идэвхи	Бк/л	1.0

Эх сурвалж: Монгол Улсын стандарт MNS 0900: 2005.

Монгол улсын бохир ус зайлцуулах стандарт (MNS 4943: 2011).

Хэмжүүр	Нэгж	Стандарт
Усны температур	Со	20
pH	-	6-9
Үнэр	Мэдрэмж	Үнэргүй
Нийт түдгэлзсэн хатуу бодис (TSS)	Мг/л	50
Биохимийн хүчилтөрөгчийн хэрэгцээ BOD5	Мг О2/л	20
Химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ COD	Мг О2/л	50
Перманганатын исэлдүүлэх чадвар	Мг О2/л	20
Нийт ууссан хатуу бодис (TDS)	Мг/л	1,000 *
Аммиак азот (NH4)	Мг N/л	6
Нийт азот (TN)	Мг/л	15
Нийт фосфор (TP)	Мг/л	1.5
Органик фосфор (DOP)	Мг/л	0.2
Устөрөгчийн сульфид (H2S)	Мг/л	0.5
Нийт төмөр (Fe)	Мг/л	1
Хөнгөн цагаан (Al)	Мг/л	0.5
Мангани (Mn)	Мг/л	0.5
Нийт хром (Cr)	Мг/л	0.3
Зургаан валентын хром (Cr6+)	Мг/л	Байхгүй
Нийт цианид (CN)	Мг/л	0.05
Чөлөөт цианид	Мг/л	0.005
Зэс (Cu)	Мг/л	0.3
Бор (B)	Мг/л	0.3
Хар тугалга (Pb)	Мг/л	0.1
Цайр (Zn)	Мг/л	1
Кадми (Cd)	Мг/л	0.03

Сурьма (Sb)	Мг/л	0.05
Мөнгөн ус (Hg)	Мг/л	0.001
Молибден (Mo)	Мг/л	0.5
Нийт хүнцэл (As)	Мг/л	0.01
Никедь (Ni)	Мг/л	0.2
Селен (Se)	Мг/л	0.02
Бериллий (Be)	Мг/л	0.001
Кобальт (Co)	Мг/л	0.02
Бари (Ba)	Мг/л	1.5
Стронций (Sr)	Мг/л	2
Ванадий (V)	Мг/л	0.1
Уран (U)	Мг/л	0.05
Тос, тослох материал	Мг/л	1
Өөх тос	Мг/л	5
Гадаргын идэвхтэй бодисууд	Мг/л	2.5
Фенол (C <sub>6</sub> H <sub>5</sub> OH)	Мг/л	0.05
Трихлорэтилен (C <sub>2</sub> HCl <sub>3</sub> )	Мг/л	0.2
Тетрахлорэтилен	Мг/л	0.1
Хлорын үлдэгдэл (Cl)	Мг/л	1
Бактериар идэвхиждэг усны гаралтай өвчин	-	1 мг усанд байхгүй

Эх сурвалж: Монгол Улсын стандарт MNS 4943: 2011.

### Гадаргын ус

Гүний усыг хамгаалах ерөнхий шаардлагыг тодорхойлсон Монгол улсын стандарт (MNS 3342: 1982)-д тээвэрлэх, хадгалах явцад газрын доорхи усыг үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүн, ахуйн хог хаягдаар бохирдуулахыг хориглоно гэж заасан байдаг. Стандартын холбогдох шаардлагууд нь:

- Газар доорхи усны нөөцийг бохирдуулах боломжтой үйлдвэрийн болон хотын хог хаягдлыг хадгалах савны түүхий эд, бүтээгдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
  - Хадгалах савны барилгын геологи-гидрогоеологийн судалгаа, геологийн материалын хөрсний нэвчилтийн тооцоо, хадгалагдаж буй химийн бодисын хэмжээ, шинж чанарт үндэслэн гүний усыг хамгаалах арга хэмжээг боловсруулах.
  - Хадгалах савуудыг ашиглахаас өмнө гоожиж буй эсэхийг шалгах.
  - Хадгалах савыг уулын бэл, голын гогцоо, голын гольдрол, үндны усны хэрэгцээнд ашигладаг геологийн хурдас ихтэй хагархай хэсгүүдийн хувьд эдгээр бус нутгуудад байгуулах боломжгүй.

- b. Ослын улмаас газрын доорх ус бохирдсон тохиолдолд эвдэрсэн газрыг хамгаалах, асгаралтыг цашид түгээхгүйгээр хамах, энэ газраас үндны ус авахыг хориглох, бохирдлын үл мөрийг арилгах ажлыг шуурхай зохион байгуулах.
- c. Гүний усны бохирдол аюултай хэмжээнд хүрсэн тохиолдолд ажиглалт, хяналтын арга нь газрын доорх усны чанар, түүний ашиглалтын зорилго, бохирдлын болзошгүй үр дагавараас хамаарна.

Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамжид санал болгох ижил стандарт байхгүй бөгөөд Монгол Улсын үндэсний стандартыг энэхүү тайландаа ашиглахаар баталсан болно.

### Хөрс

Хөрсөн дэх хүнд металын Монгол Улсын стандартыг MNS 5850: 2008-д заасан байдаг.

[Хүснэгт 9: Монгол Улсын хүнд металын стандарт \(MNS 5850: 2008\)](#)

Хэмжүүр	Хром	Хар тугалга	Кадми	Никель	Цайр
Монгол Улсын (MNS 5850: 2008)	150	100	3	150	300

Эх сурвалж: MNS 5850: 2008.

Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамжид санал болгох ижил стандарт байхгүй бөгөөд Монгол Улсын үндэсний стандартыг энэхүү тайландаа ашиглахаар баталсан болно.

### Дуу чимээ

Монгол улсын дуу чимээний стандартыг MNS 4585: 2007 үндэсний стандартад тусгасан бөгөөд үүнийг ДЭМБ-аас гаргасан олон улсын холбогдох удирдамжтай (ЭМЭМ-ийн зааварчилгаа) 10-р хүснэгтэд харьцуулан харуулсан болно. ДЭМБ-ын стандартууд нь мэдрэмтгий рецепторуудын Монгол Улсын стандарттаас илүү хатуу ба дэд төсөл нь мэдрэмтгий рецепторт ойр үед ДЭМБ-ын стандартыг хэрэглэнэ.

[Хүснэгт 10: Монгол Улсын дуу чимээний стандарт \(MNS 4585: 2017\) болон ДЭМБ-ын заавар.](#)

Хэмжүүр	MNS Стандарт Дб(А)		ДЭМБ-ын заавар Дб (A)	
	Өдрийн цаг	Шөнийн цаг	Өдрийн цаг	Шөнийн цаг
	07:00 – 23:00	23:00 – 07:00	07:00 – 22:00	22:00 – 07:00
Олон нийтэд орчны дуу чимээний үзүүлэх хамгийн дээд хэмжээ			ДЭМБ ангилал I - Сууршлын, институтын, боловсролын: 55	ДЭМБ ангилал I - Сууршлын, институтын, боловсролын: 45
	60	45		
			ДЭМБ ангилал II - Аж үйлдвэрийн, худалдаа үйлчилгээний: 70	ДЭМБ ангилал II - Аж үйлдвэрийн, худалдаа үйлчилгээний: 70

Эх сурвалж: MNS 4585: 2007 болон ДЭМБ Дуу чимээний чанарын удирдамж (1999) ОУСК-ын байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамж (2007)

## Бусад холбогдох стандартууд

Сүүлийн 1 милийн замын ажил инженерчлэлийн ажилтай холбогдож байгаа тул дэд төслийг хэрэгжүүлэх явцад гэрлийн гялбаа/тусгал, анивчихыг арилгах, замд холбох, ажлын байрны дуу чимээний нөлөөлөл гэх мэт Дэлхийн банкны ЭЭМ-ийн удирдамж гэх мэт бусад шаардлагыг дагаж мөрдөнө.

### Тусгай хамгаалалттай газар нутаг

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994 оны 11 дүгээр сарын 15) нь байгалийн ландшафт, ховор амьтан, ургамал, түүх соёлын дурсгалт газар, байгалийн үзэсгэлэнт газруудыг хамгаалах зорилготой.

Энэхүү хуульд улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дөрвөн ангилалд хуваана: i) дархан цаазат газар; ii) үндэсний байгаль хамгаалах цэцэрлэгт хүрээлэн; iii) байгалийн нөөц газар; iv) хөшөө дурсгал. Дархан цаазат газар нутгийг байгалийн хэлбэр, хөрс, ус, амьтан, ургамлын аймгийн онцлог, хүний үйл ажиллагаанд өртөмтгий байдлыг харгалzan цаашид гурван бүсэд хуваана: i) онгон дагшин бүс; ii) хамгаалалтын бүс; iii) хязгаарлагдмал ашиглалтын бүс.

Онгон дагшин бүсэд зөвхөн байгалийн унаган төрхийг хадгалах шаардлагад нийцсэн хамгаалалтын үйл ажиллагаа явуулна. Судалгаа, хянан шалгах ажиллагааг зөвхөн ажиглалтын аргаар байгалийн онцлогт хохирол учруулахгүйгээр явуулна. Энэ бүсэд бусад бүх үйл ажиллагааг хориглоно. Хамгаалалтын бүсэд ургамал, амьтны нөхөн үржихүйг нэмэгдүүлэх, байгалийн гамшигийн улмаас учирсан хохирлыг бууруулах зорилгоор байгаль орчинд ээлтэй технологи ашигласан биотехнологийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хязгаарлагдмал ашиглалтын бүсэд байгаль орчинд ээлтэй технологи ашиглан, зохих лиценз, зөвшөөрөлтэйгээр дараах үйл ажиллагааг явуулж болно:

- хөрс, ургамлын бүрхэвчийг нөхөн сэргээх;
- ойн арчилгаа, цэвэрлэгээ;
- батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу малын тоо толгой, нас хүйс, бүтцийг зохицуулах малын тооллого, үйл ажиллагаа;
- Эрдэст ус болон бусад цэвэрлэх, ариун цэврийн нөөцийг ашиглах;
- байгаль орчны аялал жуулчлалыг зохих журмын дагуу тогтоосон маршрут, талбайн дагуу зохион байгуулах;
- аялагчид болон зөвшөөрөлтэй бусад хүмүүсийн түр оршин суух, буудаллах, ажиглалт хийх, судлах, судлах зорилгоор зохих журмын дагуу түр байр ашиглах;
- гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийх, тэдгээрийг арилжааны зорилгоор ашиглах;
- байгалийн онгон дагшин газруудад тахилга хийх, бусад уламжлалт зан үйл үйлдэх,
- тогтоосон журмын дагуу холбогдох байгалийн нөөц, эмийн болон хүнсний ургамлыг ахуйн хэрэгцээнд зориулан цуглувуж ашиглах.

Дээр дурдсан дөрвөн ангиллын тусгай хамгаалалттай газраар энэхүү дэд төслийн байршил дайрахгүй.

## **4. Дэд төслийн БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ БОЛОМЖИТ НӨЛӨӨ**

### 4.1 Байгаль орчинд үзүүлэх боломжит нөлөөлөл (барилгын болон ашиглалтын үе шат)

Байгаль орчин, нийгэмд учруулах эрсдэл ба нөлөөлөл нь төсөл хэрэгжилтийн явцад гарч болзошгүй нөлөөллийг дүн шинжилгээгээр хангаж өгнө. Энэ нь санал болгосон зам барилгын төсөлтэй холбоотой боломжит нөлөөллийг авч үзэж, сөрөг нөлөөллийг бууруулах (жишээ нь,

зайлсхийх, бууруулах, сэргээн босгох) болон төслийн эерэг үр нөлөөг бэхжүүлэх (сайжруулах гэх мэт) арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Төслийн хүлээгдэж буй гол эерэг нөлөөлөл нь муж, улсын хэмжээнд авч болох эдийн засаг, нийгмийн үр өгөөж болно. Нөгөөтэйгүүр, гол сөрөг нөлөөлөл нь амьтны амьдрах орчинг өөрчлөх, хуваах, үерийн ус, бохир үс, хог хаягдал, дуу чимээ, агаар бохирдуулагч бодис зэргээс үүсдэг ба сөрөг нөлөөллийг бууруулж, эерэг үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой, зардал багатай, байгаль орчинд ээлтэй техникийг танилцуулж байгаа болно. Мөн байгаль орчны хог хаягдаас урьдчилан сэргийлэх, багасгахад чиглэсэн тэргүүний арга техник болон түршлагыг сонгоход онцгойлон анхаарч байна. Бохирдлоос урьдчилан сэргийлэхэд төслийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг алдагдуулахгүйгээр технологийн хаягдал болон дайвар бүтээгдэхүүнийг дахин ашиглах, дахин боловсруулах зэрэг хамгийн сайн арга техникийг нэгтгэх замаар хүлээгдэж буй төслийн тогтвортой байдалд онцгой анхаарал хандуулж байна. (Irshad et al. 2015; Chatli et al. 2005). Байгаль орчинд үзүүлэх дараах эерэг ба сөрөг нөлөөллийг Монгол Улсын Зам тээврийн холболт, логистикийг сайжруулах төсөл болон БОНМТ зэргийг үндэслэн гаргасан бөгөөд цаашдын үнэлгээ, байгаль орчны суурь судалгааг тухайн газар дээр нь очиж, байгаль орчны мэргэжилтнүүдийн хээрийн судалгаа, орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх замаар гүйцэтгэнэ. Төслийн бүрийн үе шатуудад (барилга угсралтын өмнөх, барих, ашиглах) болзошгүй нөлөөлөл болон санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээг доор авч үзнэ.

#### **4.1.1 Барилга угсралтын өмнөх үе шатны хүлээгдэж буй нөлөөлөл ба түүнийг бууруулах арга хэмжээ**

Барилгын өмнөх үеийн сөрөг нөлөөлөл нь ихэвчлэн газрыг бүрмөсөн авах болон алдахтай холбоотой байдаг. Харин уг төслийн бүх үйл ажиллагаа төрийн өмчлөлгүй газар хэрэгжих тул газар чөлөөлөх асуудал гарахгүй, үүнтэй холбоотой сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах шаардлагагүй болно.

Байгаль орчны менежментийн хэд хэдэн арга хэмжээг нарийвчлан гаргасан зураг төсөл түүний дотор нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон цаашдын холбогдох төлөвлөгөөг БОНМТ-д заасан бүхий л байгаль орчны болон нийгмийн баримт бичгүүдийн дагуу хийнэ. Нарийвчилсан судалгаанд зориулан байгаль орчин, нийгмийн холбогдолтой бүх баримт бичиг, түүнд тавигдах шаардлагыг техникийн тодорхойлолт, гэрээ хэлэлцээр, ажлын нөхцөл зэрэгт тусгана.

Нарийвчилсан зураг төсөл боловсруулах үеийн бууруулах арга хэмжээ болон хяналт

Усны дээж, шинжилгээ

Усны дээжийг төслийн төлөвлөсөн газраас 5 км радиуст хэд хэдэн газраас санамсаргүй байдлаар цуглуулах ба талбайн ойр орчмын гол горхи/гол, гүний усны худаг/усны сав болон бүсад гадаргын үс зэргийг анхааралдаа авах юм. Усны чанарын шинжилгээг дээж авах бүрт стандарт аналитик аргын дагуу (стандартуудыг дурдах ёстой) бүх физик-химиийн үзүүлэлтүүдэд хийж, дараах үзүүлэлтүүдэд анхаарлаа хандуулна: pH, температур, нийт уусдаг хатуу бодис (TDS), хлорид (Cl), ууссан хүчилтөрөгч (DO), биохимиийн хүчилтөрөгчийн хэрэгцээ (BOD), химиийн хүчилтөрөгчийн хэрэгцээ (COD), нийт хатуу бодис, нийт түдгэлзүүлсэн бодис (TSS). Шим тэжээлийн шинжилгээг магадлан итгэмжлэгдсэн лабораторид хийх бөгөөд гол төлөв эвтрофикацийн элементүүд болох нитрат, нитрит, аммиак, силикатууд, фосфор, нийт фосфор (TP), нийт азот (TN) дээр төвлөрнө. Шаардлагатай бол усны микробиологийн дээжийг төслийн төлөвлөсөн талбайд хийнэ.

Хөрсний дээж, шинжилгээ

Замын барилгын ажлын явцад ялгараах бохирдолтой хэсгийг сонгон авч хөрсний дээжийг авахаар төлөвлөж байгаа болно. Дээж авах газраас 0-15 см-ийн гүнд тус бүр гурван нийлмэл дээж авна. Дээжийг ариутгасан полиэтилен уутанд хийж, боловсруулах лабораториид хүргэх ба дараах үзүүлэлтүүдийг итгэмжлэгдсэн лабораториид шинжилнэ: Хөрсний pH, Органик нүүрстэрөгчийн хувь (ОС), Органик бодис (ОМ), Нийт азот (N) Боломжтой фосфор (Р) натри (Na), кали (К). Шаардлагатай бол хөрсний дээжээс микробиологийн дээж авах ажлыг төлөвлөсөн төслийн талбайд хийнэ.

#### Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

БОННҮ-ний явцад төслийн нөлөөллийн бүс дэх байгаль орчин, нийгмийн эмзэг байдлын иж бүрэн, нарийвчилсан судалгааг тусгай хамгаалалттай газар нутаг, экологийн эмзэг бүс, байгалийн амьдрах орчин зэргийг багтаан орон нутгийн байгууллага, нөхөрлөлтэй зөвлөлдөх замаар явуулна.

#### Биологийн олон янз байдлын хээврийн судалгаа

Монгол Улсын хуулиар хориглосон аливаа үйл ажиллагаа, тусгай хамгаалалттай газар нутагт ихээхэн аюул учруулах, ховордсон, ховордсон амьтдад аюул учруулах, амьдрах орчныг нь сөргөөр өөрчлөх үйл ажиллагаа, археологийн болон палеонтологийн дурсгалт газар, тахилгат уулс зэрэг соёлын ач холбогдолтой газрууд, ой модыг сүйтгэх, бэлчээрийн талбай, эвдэрсэн тал, ой модыг үерт автуулах далан, усны хяналтын бусад байгууламж барих, эвдрэлд ороогүй ойгоор дамжин өнгөрөх замуудыг барих, шинэчлэх, засварлах зэрэг ажлууд төслийн төлөвлөгөөний жагсаалтад багтаагүй ба эдгээрийг төслийн талбайд хийхгүй. Ялангуяа Угтаалцайдам сумын нутаг дахь халиун буга, зээрийн нүүдлийн замд биологийн олон янз байдлын хээрийн судалгааг хийх ба хэрэв эцсийн миль холбох авто замаас үүдэлтэй хариун буга, зээрийн сүрэгт үзүүлэх нөлөөлөл тогтоогдвол зээр хамгаалахад чиглэсэн биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөг Дэлхийн Банкны санхүүжилтээр Угтаалцайдам суманд баригдах замын ажлын тендерээс өмнө боловсруулах бөгөөд авто замын барилгын эцсийн нарийвчилсан зураг төсөл болон гүйцэтгэг нартай байгуулах гэрээний тавигдах шаардлагуудад шигтгэнэ.

Дэлхийн банкны санхүүжилтээр Угтаалцайдам суманд баригдаж буй холбох замын ажлын тендерийн өмнө соёлын өвийн судалгааг гүйцэтгэнэ. Дэлхийн Банкнаас санхүүжүүлж буй холбох замын дагуу ямар нэгэн өвийн дурсгалт газрууд, тэдгээрийн хамгаалалтын бүсүүд тогтоогдсон тохиолдолд өвийн дурсгалт газруудаас зайлсхийх үүднээс холбох замын маршрутыг өөрчилнө.

#### **4.1.2 Барилга, угсралтын шатны хүлээгдэж буй ажлуудын нөлөөлөл, тэдгээрийн бууруулах арга хэмжээнүүд**

##### **Эерэг нөлөө**

Барилга, угсралтын шатанд дараах эерэг нөлөө бий болох магадлалтай байгаа:

Монгол Улсын махны салбарын нэмүү өртгийн сүлжээний тээврийн холбоос, логистикийн үр ашигтай байдал сайжирна.

Ажлын байр бий болгох боломжууд

Төслийн барилга, угсралтын явцад барилгын салбарт ажлын байр олноор бий болно. Ажлын байрны боломжууд нь эдийн засаг, нийгэм хоёуланд нь үр өгөөжтэй. Ур чадвар үл шаардах барилга, угсралтын ажлын байруудад орон нутгийн суугчдыг ажиллуулна. Зөвхөн төслийн явцад бий болох ч гэлээ барилга, угсралтын үеэр энгийн хөдөлмөр эрхлэгчид, өрлөгчид, мужаан, модчид, цахилгаанчид, сантехникчид зэрэг олон ажлын байр бий болно.

Барилгын ажилчдын шинээр бий болгох бизнесийн боломжууд

Шаардлагатай байгаа барилгын ажилчид олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд бэлэн зах зээл нь болж өгөх тул төслийн талбайн ойролцоо жижиглэнгийн худалдаа, орон сууц, хүнсний дэлгүүр гэх мэт жижиг хэмжээний бизнесийн хэд хэдэн боломж бий болгоно.

Барилга, угсралтын ажилд ашиглах материалуудад зах зээл болж өгөх

Төслийн ажилд их хэмжээний материалууд нийлүүлэх шаардлагатай бөгөөд үүний заримыг нь орон нутгийн зэргэлдээх газруудаас авна. Тухайлбал барилгын чулуулгийн компаниуд, тоног төхөөрөмжийн дэлгүүр, хувь хүмүүст барилгын материал нийлүүлэх зах зээл бий болгоно.

Барилгын материал, нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэгчдийн орлого нэмэгдэнэ. Түүнчлэн барилгын материал болон нийтийн аж ахуйн бусад үйлчилгээ үзүүлэгчдэд бүтээгдэхүүнээ худалдах шинэ зах зээлийг бий болгох юм. Тэдгээр бизнесийн цэвэр ашгийг дэмжсэнээрээ мөн ихээхэн давуу талыг олгоно. Цайны газар гэх мэт бусад жижиг бизнесүүд ч мөн барилгын үйл ажиллагаанд хамрагдана.

##### **Сөрөг нөлөөлөл**

Цэвэрлэгээ, газар тэгшлэлт, барилгын материалын тээвэр, машин механизм, нийтийн аж ахуйн системийн сууринуулалт зэрэг ажлууд төслийн барилгын шатанд хамрагдаж байгаа. Төслийн барилгын ажилтай холбогдолтой болзошгүй сөрөг үр дагаврууд нь:

Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Замын угсралтын ажил ба тэдгээрт холбогдох үйлчилгээнүүд хүлээгдэж буй төслийн талбайн ургамал, амьтны аймагт нөлөөлнө. Ургамлын амьдрах орчин алдагдах, ургамлын бүлгэмдэлийн байгалийн тогтвортгүй байдал нэмэгдэх зэрэг болзошгүй сөрөг нөлөөллүүд үүнд багтаж байгаа. Үүний адилаар барилгын талбайн үйл ажиллагаа, тэдгээрээс гарах дуу чимээ нь барилгын болон зэргэлдээх талбайн ихэнх орчинд буй ургамлын аймагт түр хугацаанд нөлөөлнө. Замын эцсийн холбоосны улмаас улаан буга, цагаан зээрт ямар нөлөө учруулах нь тогтоовол Угтаалцайдам сумд Дэлхийн Банкны санхүүжилттэй хийгдэх замын барилгын ажлын тендер эхлэхээс өмнө улаан буга, цагаан зээрийн нүүдлийн замыг тогтоох биологийн олон янз байдлын хээрийн судалгааг гүйцэтгэж, улаан буга, цагаан зээрийг хамгаалахад чиглэсэн нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг санал болгосон биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө

боловсруулна. Нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсний дараа барилгын угсралтын ажлын шатанд амьтан, ургамлын аймагт учрах нөлөөлөл хамгийн бага байх төлөвтэй байгаа.

Газрын бүрэн бүтэн байдалд учруулах нөлөө болон газар ашиглалтын хэлбэр

Авто замын болон нийтийн аж ахуйн системийн бүтээн байгуулалт нь төслийн талбайд өөрчлөлт оруулах ч газар чөлөөлөх, тэгшлэх, ухаж гаргасан материалыг хаях зэрэг нь төслийн талбайн газрын бүрэн бүтэн байдалд нөлөөлөх шалтгаан болж болно.

Агаарыг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх

Авто замыг ашиглаж буй хэрэглэгчдийн тоо хоёр дахин нэмэгдэхээр байгаа тул хүлэмжийн хийн ялгарал дагаад нэмэгдэнэ.

Авто замын бүтээн байгуулалтын агаарын чанарт учруулах нөлөөлөл нь бага, богино хугацааных байх төлөвтэй. Зам болон барилгын бүтээн байгуулалтын үеэр төслийн талбайд сул шороо ихээр босож, автомашины хөдөлгөөн, ачаа буулгах, ачих үйл ажиллагааны улмаас агаарын чанар олон улсын болон үндэсний стандартад зөвшөөрөгдөх хэмжээнээс давж, хүн амын эрүүл мэнд, хөрс, ургамлын тариаланд сөргөөр нөлөөлж болзошгүй. Автомашин, техник, хэрэгслийн яндангийн хий, утаа агаар болон хөрсөнд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Барилгын тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны улмаас хөдөлгүүр, яндангийн утаа, сул шороо агаарт тархдаг. Төсөлд ашиглах тоног төхөөрөмж мөн азотын исэл ( $\text{NO}_x$ ), гидрокарбон, жижиг ширхэгт тоосонцор, болон дизель түлшний хэрэглээнээс бага хэмжээний хүхрийн давхар исэл ( $\text{SO}_2$ ) ялгаруулна. Гэхдээ багахан хэмжээгээр зөвхөн орон нутгийн агаарын чанарт сөргөөр нөлөөлөх төлөвтэй байна.

Дуу чимээ, чичиргээ

Авто замын бүтээн байгуулалтын явцад барилгын арга барил, ашиглах тоног төхөөрөмжөөс шалтгаалаад орчны дуу чимээ түр хугацаанд нэмэгдэх магадлалтай. Санал болгож буй авто замын ажлууд дундаас хамгийн их дуу чимээ гаргах үйл ажиллагаа нь бульдозер, хусагч, ачааны машин зэрэг хүнд даацын техник хэрэгслүүд бөгөөд барилгын ажлын явцад түр хугацаанд үргэлжилнэ.

Хөрсний доройтлоос сэргийлэх

Төслийн хүрээнд хийгдэх хөрсний гадаргуу хуулах, малтлага хийх ажлууд болон бохир үсны системд лаг цутгах, тэр дундаа борооны улиралд барилгын ажил хийгдэвэл төслийн талбайд хөрсний элэгдлийг нэмэгдүүлнэ. Барилгын ажлын явцад хөрсний гадаргуу суларч, тоосжилт нэмэгдэнэ. Түүнчлэн үйлдвэрлэлийн шатны хаягдлыг зөв зохистой боловсруулахгүй бол хүн болон малын эрүүл мэндэд шууд болон шууд бус байдлаар нөлөөлнө.

Суларсан хөрсөнд агуулагдсан эсвэл нийлсэн бохирдуулагч бодисууд мөн орон нутгийн гол/горхинд хаягдаж, нөлөөлөлд өртөх талбайн хөрсний үржил шимд сөргөөр нөлөөлөх магадлалтай. Хяналтын зохих арга хэмжээг цаг хугацаанд нь авснаар талбайн хөрсний алдагдал, шаваржилтыг бууруулаад зогсохгүй зөвлөн налуу, үсны эх үүсвэрийн тундасжилтыг багасгах боломжтой.

Усны чанар, эрэлтэд учрах нөлөө

Барилга, үйл ажиллагааны явцад газар ухах, хөдөлгөх явцад гадарга болон гүний үсны чанар бохирдож, гидрологийн нөхцөл өөрчлөгдөх боломжтой (жишээ нь Дэлхийн Банкны 2003 оны судалгаа). Эдгээр үйл ажиллагааны улмаас ухсан хөрс үсны сав газрыг ихээр булингартуулж (хатуулаг бодисууд ихээр урсах), тунадасжуулснаар гадаргын урсац, хөрсний элэгдэл нэмэгдэх

магадлалтай байгаа нь орчны бохирдлын хамгийн гол эх үүсвэрүүд. Үүнээс гадна төслийн барилгын явцад хаягдах магадлалтай тос, тослог эд, шатахуун, барилгын материалууд усны чанарыг доройтуулж болзошгүй. Барилгын ажил болон ашигласан материалуудын улмаас хаягдах бохир ус орчны усыг бохирдуулах магадлалтай. Үндны усыг ихээр хэрэглэх нь мөн гүний усны түвшинг шавхах магадлалтай. Үндны болон аж үйлдвэрлэлийн зориулалттай усыг тогтмол хянах замаар орон нутгийн суугчид болон ан амьтны эрүүл мэндийг хамгаалах хэрэгтэй. Урт нэртэй хуульд зааснаар усны эх үүсвэр болон ойн талбайгаас 50-200 метр зайд аливаа үйл ажиллагаа явуулахаас зайлсхийх хэрэгтэй. Тус хууль нь ус болон газрын бохирдоос сэргийлэхэд зориулагдсан.

#### Хатуу хог хаягдал

Авто зам, дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой хатуу хог хаягдлууд хуримтлагдана. Гологдсон, илүүдэл материал, илүүдэл хаягдал, ухаж, малтаж гаргасан болон хортой материалууд энэ төрлийн хаягдын эх үүсвэрүүд болно. Гэрээ байгуулагчийн барилгын кэмп дахь тоног төхөөрөмжийн нэгдсэн хяналт, арчилгаа, засвар үйлчилгээ, цаашлаад лаг, цаасан уут, хоосон картон зэрэг ажилчдын ахуйн хэрэглээнээс хортой материалууд ялгарах магадлалтай. Барилгын шатны төгсгөлд гэрээ гүйцэтгэгчийн барилгын кэмпийг нүүлгэхэд мөн хог, хаягдал ялгарна. Энэ төрлийн татан буулгах ажлаас голодол материалууд, цаасан уут, хоосон картон гэх мэт хаягдал гардаг.

#### Шингэн хаягдал

Барилга, угсралтын шатанд олон өөр төрлийн шингэн хаягдал ялгарах магадлалтай. Энэ дунд машин, техник, төхөөрөмжийн тос, будаг, хаягдал тос, битумен, цэвэрлэгээний хог хаягдал зэрэг багтана. Хүнд даацын техник хэрэгслийн арчилгаа тааруу үед барилгын талбайд тос, шатахуун алдагдах магадлалтай нь орчин тойрны хөрс болон усыг бохирдуулах эрсдэлтэй. Байгаль орчинд гидрокарбон гадагшууллах нь дэд хөрс, гүний усны бохирдол үүсгэх зэрэг олон өөр сөрөг нөлөөлөл учруулна; цаашлаад агаарын бохирдол, түймэр, амаар хэрэглэсэн, амьсгалсан, залгисан тохиолдолд хүний эрүүл мэндэд аюултай.

#### Ажилчдын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал

Дэд төслийн барилга, угсралтын ажлын үед ажилчид цахилгаан, дуу чимээ, чичрэлт, тоосны улмаас, хүнд даацын техник хэрэгсэлтэй харьцах үедээ, тээврийн хэрэгслийн ачааллын улмаас, унах, унаж байгаа зүйлд өртөх, халтрамтхай гадаргуу, галын аюул, өвчлөлтэй орчинд ажиллах зэргээр аюулд орох магадлалтай. Эдгээр аюул нь барилгын ажлын явцад эрсдэл дагуулна.

#### Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал

Барилгын дэд төсөл нь авто замын ачаалал, түгжрэл үүсгэх, барилгын үйл ажиллагааны үед гал гарах, эд материал унагах, асгах, барилгын талбайд зөвшөөрөлгүй нэвтэрсний улмаас эрсдэл үүсэх зэрэг олон нийтийг тавгүйтүүлэх, аюулд оруулах эрсдэлүүд бий болгох магадлалтай. Үүнээс гадна ажилчдын кэмп, түр ажиллахаар шилжин ирэх ажилчдын урсгалаас үүдэлтэй нийгмийн зөрчил, болзошгүй өвчний тархалт гарах боломжтой. Эдгээр нөлөөллүүд нь ач холбогдолын хувьд бага, дэд төслийн барилгын цаг хугацааны хувьд дундаж хугацаанд үргэлжилнэ.

#### Биет соёлын нөөц

Талбайн тандалт судалгаанаас харахад дэд төслийн талбай болон ойр орчимд биет соёлын нөөц байхгүй. Гэхдээ барилгын ажлын явцад одоогоор мэдэгдэхгүй байгаа биет соёлын нөөц хөндөгдөх магадлал бий.

#### 4.1.3 Хүлээгдэж буй үйл ажиллагааны шатны нөлөөлөл, тэдгээрийг бууруулах арга хэмжээнүүд

Авто замын дуу чимээ нэмэгдэх, амьтдын байгалийн бэлчээрийн замыг нь хаах зэрэг байгаль орчны асуудлууд үүсэх магадлалтай. “MNS 6735:2018 Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага”-ын дагуу Авто замын бүтээн байгуулалтын шаардлагатай стандарт тоног төхөөрөмжийг сууринуулах, үйл ажиллагаа хариуцсан гол нэгжийг байгуулах.

#### Эерэг нөлөөлөл

Үйл ажиллагааны шатанд бий болох эерэг нөлөөллийг дараах байдлаар урьдчилан таамаглав:

Шинэ замын бүтээн байгуулалттай холбоотойгоор замын холбоос, орчин тойрны өнгө үзэмж сайжирч, авто замаас үүсэх тоосжилтыг бууруулж, амьдрах орчныг сайжруулна.

Төв аймагт шинэ хөрөнгө оруулагчдыг татах

Санал болгож буй бүтээн байгуулалтаар холбоос авто замын холбоос сайжирч, аймгийн эдийн засгийн өсөлтийг дэмжиж, хөрөнгө оруулалт татах боломж нэмэгдэнэ.

Шууд болон шууд бус ажлын байр бий болгох

Төслийн үйл ажиллагааны шатанд орон нутгаас олон хүн ажилд авахаар байгаа нь оршин суугчдын нийгэм, эдийн засгийн байдалд эерэгээр хувь нэмэр оруулна. Тухайлбал төслийн талбайн ойролцоо оршин суудаг хүмүүст шууд ажлын байр бий болох төлөвтэй байгаа.

Орон нутгийн захиргааны орлого нэмэгдэх

Сайжруулсан байгууламж, станцуудын хэрэглээ зэргээр энэхүү төсөл нь орон нутгийн захиргааны орлогыг холбогдох татвар, хураамжаар дамжуулан нэмэгдүүлнэ.

#### Сөрөг нөлөөлөл

Автомашины дуу чимээ

Цээл, Угтаалцайдам хүртэлх замын холболт ашиглалтад орсноор авто замын ачаалал нэмэгдэж, хүнд даацын тээврийн хэрэгсэл ихээр дамжин өнгөрдөг болж, дуу чимээ нэмэгдэх магадлалтай.

Нийгэм, эдийн засаг, оршин суугчдын эрүүл мэнд, тав тухтай байдалд учруулах нөлөө

Маш олон эерэг үр дагавраас гарахаар байгаа ч замын бүтээн байгуулалтын үлмаас дараах гол асуудлууд үүсэх төлөвтэй байгаа: Газар ашиглалтын маргаан, газрын үнэлгээ буурах.

Санал гаргагч талын сонгосон талбайд хөдөө, орон нутгийн суугчид байгаа тул тэдний тав тухыг алдагдуулах асуудал бий болгож мэднэ. Төслийг болгоомжтой удирдаж явуулахгүй бол зэргэлдээх оршин суугчдын тав тухыг алдагдуулах өндөр эрсдэлтэй бөгөөд оролцогч талууд үүний нөлөөлөлд өртөх боломжтой. Төслийн оршин суугчдын эрүүл мэнд, тав тухад үзүүлэх нөлөөлөлд дуу чимээ, тоосжилт багтаж буй юм.

Ургамал, амьтны аймаг

Авто зам дагуу дуу чимээ нэмэгдсэнээр хөхтөн амьтдын экологийн горим, нүүдлийн хэв маягийг алдагдуулах магадлалтай. Хүлээгдэж буй төсөл нь хаягдаар хооллодог зарим төрлийн шувуудыг татаж, бусад ан амьтан, тэр дундаа амьдрах орчны өөрчлөлтөд мэдрэг амьтдыг үргээх магадлалтай. Тухайлбал шөнийн цагаар дээш хурц гэрэл тусах, эсвэл томоохон талбайг хамарч буй гэрэлтүүлэг нь шөнөөр шувуудын нүүдэлд саад болно.

Утгаалцайдам сүм нь 200 орчим улаан буга<sup>6</sup>(*Cervus Elaphus*), 800 орчим цагаан зээр<sup>7</sup> (*Procapra gutturosa*)-ийн нүүдлийн замд оршдог. Улаан буга, цагааны зээрийг хамгаалах, нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөнд багтаж буй бөгөөд уг төлөвлөгөөг сайтар хэрэгжүүлж, хяналт тавих хэрэгтэй.

Төслийн үйл ажиллагааны шатанд хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл тулгарах магадлалтай. Тухайлбал ажилчид ослын улмаас бэртэх, галд өртөх эрсдэлүүд үүнд багтана.

#### 4.1 Нийгмийн болзошгүй нөлөөлөл (барилга, угсралт болон үйл ажиллагааны үе шатууд)

4.1.1 Барилгын ажлын явцад учрах нийгмийн нөлөөлөл ба тэдгээрийг бууруулах арга хэмжээнүүд

Бүтээн байгуулалтын ажлын явцад хийгдэх авто замын холболтуудын хамгийн гол сөрөг нөлөөллүүд нь: замын хөдөлгөөний аюулгүй байдал, замын өдөр тутмын ачааллыг нэмэх, хөдөлмөрийн урсгал (SEA/SW үүнд хамаарна), барилгын ажлын улмаас болон материал татан авах явц дунд тодорхой газар нутагт нэвтрэх боломж хязгаарлагдах.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал, замын өдөр тутмын ачаалалд хөндлөнгөөс нөлөөлөх

Материалууд татан авахад тээвэр үйлдэх тээврийн хэрэгслүүд болон авто замыг барьж буй гэрээ гүйцэтгэгчийн тээврийн хэрэгслүүд замын ачаалалд голцуу нөлөөлнө. Авто ослоос урьдчилан сэргийлэх алхмууд хэрэгтэй болно. Тухайлбал барилгын талбайд хашаа зоох, анхааруулах самбар байрлуулах, түр ашиглах зам гаргах гэх мэт.

Хөдөлмөрийн урсгал (SEA/SW үүнд хамаарна)

Авто замын бүтээн байгуулалтад шаардлагатай ажилтны тооноос хамаарч ажилчдын кэмп босгох шаардлагатай болох бөгөөд орон нутгийн суугчидтай ойр байх хэсэгт эрсдэлийг үнэлнэ. Гэрээ гүйцэтгэгчид барилгын ажилчдыг СОС-ийн сургалтад хамруулах хэрэгтэй бөгөөд холбогдох шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж өгнө.

Газрын хүртээмж хязгаарлагдах

Авто замын холболт хийх газрууд болон материал татах авах талбайг түр ашиглах үед оршин суугчид тухайн газарт түр хугацаанд нэвтрэх боломжгүй болох магадлалтай. Оршин суугчдын бүрэн дэмжлэгийг авахын тулд барилгын ажил эхлэхээс өмнө оролцогч талуудыг тодорхойлно.

Оролцогч талуудыг тодорхойлж, авто замын холболт хийгдэх газрын орчин тойрны суугчидтай тулж ажиллах алхмуудыг нарийвчлах зорилго бүхий ТОДТ (SEP)-ийг ЗТХЯ боловсруулсан. Барилгын аливаа ажил эхлэхээс өмнө авто замын холболт хийгдэх газрууд болон материал татан авах талбайн ойр орчинд оршин сууچ оролцогч талууд, тухайлбал малчин өрхүүдтэй төслийн нөлөөллийн талаар хэлэлцүүлэг явуулна. Төслийн талаарх мэдээлэл болон хэлэлцүүлгүүдийн тайланг оролцогч талуудад хамгийн хүртээмжтэй, богино хугацаанд хүлээн авах боломжтой байдлаар хүргэж, талуудын байр суурийг сонсоно.

4.1.2 Үйл ажиллагааны явцад учрах нийгмийн болзошгүй нөлөөлөл, тэдгээрийг бууруулах арга хэмжээнүүд

Авто замын холболт хийх талбайн хурдны жишиг загвар нь 50 км/ц-аас 80 км/ц хооронд байхаар байгаа. Энэ нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрсдэл бий болгоно. Тэр дундаа тосгон/суурин газрын ойролцоо хэсгүүдэд. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг үнэлэх бөгөөд

<sup>6</sup> Утгаалцайдамд улаан буга (*Cervus Elaphus*) үзэгдэв: <https://news.mn/r/2391650/>

<sup>7</sup> Цагаан зээр(*Procapra gutturosa*)-ийн нүүдэл: <https://mongolia.wcs.org/wildlife/mongolian-gazelle.aspx>

замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай арга хэмжээнүүдийг үүнд багтаана. Тухайлбал хурдны хязгаар, орон нутгийн суугчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар боловсрол олгох ажлууд.

## **5. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛҮҮДИЙГ БУУРУУЛАХ, ХАМГААЛАХ АЖЛУУД**

Цээл, Угтаалцайдам дахь замын бэлтгэл ажил, бүтээн байгуулалт, үйл ажиллагааны явцад учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах зохистой арга хэмжээнүүдийг дэлгэрэнгүй зураг төсөл болон төслийн БОНМХ-ний дагуу боловсруулна. Нөлөөлөл болон нөлөөллийг бууруулах ажлуудыг Хүснэгт 2-т нарийвчилж харуулав.

Нөлөөллийг бууруулах бүх арга хэмжээнүүдийг дэд төслийн нарийвчилсан зураг төсөл, тендерийн баримт бичгүүд, барилгын гэрээнүүд, үйл ажиллагааны менежментэд нэгтгэж өгнө. Эдгээр арга хэмжээнүүдийн үр дүнтэй байдлыг байгаль орчны хяналт, шалгалтаар үнэлж, цаашид үргэлжлүүлэх, сайжруулах, өөрчлөлт оруулах эсэхийг нь шийдэх хэрэгтэй.

**Хүснэгт 5 Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд**

Үйл ажиллагаа/Нөлөөлөл	Бууруулах/Сэргийлэх арга хэмжээнүүд	Хэрэгжүүлэх байгууллага	Хяналт тавих байгууллага	Өртөг/Төсөв
<b>Барилгын өмнөх/Зураг төсөл гаргах шат</b>				
Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), нэмэлт үнэлгээ	<ul style="list-style-type: none"> <li>- Зураг төслийг бодитоор гаргаж, хадгалах талбай, дуу чимээ ихтэй машин, механизм зэрэг бохирдлын эх үүсвэрүүдийг байгууламжийн хил хязгаараас хангалттай хол зайд байрлуулах хэрэгтэй;</li> <li>- “MNS 6735:2018 Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага”-ын дагуу малын гарц зэрэг замын гармуудын зураг төслийг гаргаж, сууринуулах;</li> <li>- Соёлын үнэт өв болсон газруудыг сүйтгэхээс зайлсхийх;</li> <li>- Газрын хүртээмж хязгаарлагдсаны улмаас өрхүүдийн амьжираанд учруулах нөлөөг аль болох бага байлгах;</li> </ul>	ТУА	ЗТХЯ/ДБ	ТУА
Тендер, гэрээний удирдлага	<ul style="list-style-type: none"> <li>- БОНМТ-ний нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг тендерийн баримт бичгүүдэд тусгах;</li> <li>- Байгаль орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг гэрээ гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгах;</li> </ul>	ТУА	ЗТХЯ/ДБ	ТУА төсөв
Биологийн олон янз байдлын талбайн судалгаа, менежментийн төлөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Замын эцсийн холбоосны улмаас улаан буга, цагаан зээрт ямар нөлөө учруулахыг нь тогтоогдсон тохиолдолд Угтаалцайдам сүмд Дэлхийн Банкны санхүүжилттэй хийгдэх замын барилгын ажлын тендер эхлэхээс өмнө улаан буга, цагаан зээрийн нүүдлийн замыг тогтоох биологийн олон янз байдлын хээрийн судалгааг гүйцэтгэн, биологийн олон янз байдлын төлөвлөгөө боловсруулж, улаан буга, цагаан зээрийг хамгаалах зорилго бүхий нөлөөллийг бууруулах арга хэмжээг санал болгож, эцсийн нарийвчилсан зураг төсөл болон авто замын барилгын ажлын гэрээнүүдийн шаардлагуудад тусгана. ЗТХЯ нь хээрийн судалгаа, Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөний ажлын даалгаврын боловсруулах бөгөөд ингэхдээ БОНМХ-г тусган, уг арга хэмжээ, түнээс гарах үр дүнг БОНС6-гийн</li> </ul>	ТУА	ЗТХЯ/ДБ	ТУА төсөв

	шаардлагад нийцүүлнэ. Ажлын даалгаврыг хээрийн судалгаа эхлэхээс өмнө Дэлхийн Банкаар хянуулж, зөвшөөрөл авна.			
Газар ашиглалтын хязгаарлалт	<ul style="list-style-type: none"> <li>- Зам болон материалууд татан авах талбайн ойролцоо оршин суудаг оролцогч талуудыг тогтоож, хэлэлцүүлэг явуулах замаар амьжиргаанд нь үзүүлэх нөлөөллийн түвшинг үнэлэх;</li> <li>- Газрын түр болон урт хугацааны ашиглалтын нөлөөллийг аль болох бага байлгаж, бууруулах.</li> </ul>	ТУА	ЗТХЯ	ТУА төсөв
Соёлын өвийн судалгаа	<ul style="list-style-type: none"> <li>- Угтаалцайдам сумд Дэлхийн Банкны санхүүжилтээр хийгдэх замын холболтын тендерийн ажил эхлэхээс өмнө соёлын өвийн судалгаа хийнэ. Судалгаагаар Дэлхийн Банкны санхүүжилттэй замын холболтын ажилд аливаа соёлын өвийн талбай болон хамгаалалттай бүсүүд тогтоогдвол тэдгээрээс хол байлгах зорилгоор авто замын холболтын чиглэлийг өөрчилнө.</li> </ul>	ТУА	ЗТХЯ/ДБ	ТУА төсөв
Талбайд тусгайлан зориулсан Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө	Аливаа барилгын ажил эхлэхээс өмнө тендерт ялсан гэрээ гүйцэтгэгч нь тухайн талбайд тусгайлан боловсруулсан Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөөг боловсруулж, ТУА болон холбогдох эрх баригчдад хүргүүлэх шаардлагатай бөгөөд үүнд ЕСОР, БОНМХ, БОНМТ болон тендерийн баримт бичгүүдэд шаардах доор дурдсан бусад БОН-ийн баримт бичгүүдэд үндэслэсэн байгаль орчин, нийгмийн аюулгүй байдлын зохицуулалт/зураг төсөл багтана.	Гэрээ гүйцэтгэгчид	ТУА/ЗТХЯ	ТУА төсөв
Олон нийтийн хэлэлцүүлэг, талбайн баримт бичгүүд	Барилгын ажил эхлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэгүүд явуулна. Барилгын ажлаас өмнө төслийн талбайг баримтжуулж, хяналт тавина (хяналтын төлөвлөгөөнөөс харна уу).	ТУА/ЗТХЯ	ДБ	ТУА төсөв
Барилгын үе шат				
Талбайг бэлдэх	<ol style="list-style-type: none"> <li>1. Барилгын талбайг урьдчилан тооцсон хүрээнд хязгаарлах хэрэгтэй. Талбайн үсны хэрэглээг аль болох бага байлгаж; мэдээллийн самбар, тэмдэглэгээг байрлуулна;</li> <li>2. Барилгын талбайг зөв зохистой хучих хэрэгтэй;</li> <li>3. Барилгын ажил дууссаны дараа барилгын талбайг ашиглалтын төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээнэ.</li> </ol>	Туслан гүйцэтгэгчид	ТУА/ЗТХЯ	Гэрээ гүйцэтгэгчийн төсөв

<p>Ургамал, ан амьтны аймаг</p> <p>Талбайг цэвэрлэх үед, барилгын ажлын болон дараах үед замын хөдөлгөөнийг буруу удирдан явуулснаас угуул болон таримал ургамал устах гэх мэтээр ургамалд нөлөөлөл учрах магадлалтай.</p> <p>Түүнчлэн ажилчид болон хүнд даацын техник хэрэгслээс ялгарах дуу чимээ нь зэрлэг ан амьтанд сэргөөр нөлөөлж, тухайн талбайгаас нүүхэд хүргэх магадлалтай.</p> <p>Хүний оролцоотой сөрөг нөлөөлөлд барилгын ажилчдын хууль бус ан багтах бөгөөд энэ нь зэрлэг ан амьтдын тоо толгой буурахад нөлөөлнө.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Барилгын талбайн эргэн тойронд цэвэрлэх/хөрс хуулах ажлыг аль болох бага байлгах</li> <li>- Барилгын ажлын үеэр машин, механизмын хөдөлгөөнийг хязгаарлах/хянах.</li> <li>- Нөхөн сэргээх боломжтой байдлаар ургамлыг шилж, цэвэрлэх</li> <li>- Барилгын талбайгаас сугалсан ургамлуудыг дахин суулгах.</li> <li>- Нөхөн сэргээх төлөвлөгөөнд талбайн экологийн статусыг сайжруулах арга хэмжээнүүдийг багтаах хэрэгтэй.</li> <li>- Төслийн талбайд ургамлын аймгийг сүйтгэх, устгахаас аль болох сэргийлэх хэрэгтэй.</li> <li>- Иймд талбайн ургамлын хөрсийг бутлахаас зайлсхийж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хэт ачааллын улмаас дэгдэх тоосонцрын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авна. Доройтсон талбайг нөхөн сэргээх, ургамал тарихыг зөвлөж байна.</li> <li>- Барилгын үйл ажиллагааны улмаас зарим ан амьтдын амьдрах орчин устах магадлалтай. Үйл ажиллагааны шатанд шөнийн цагаар эмзэг хүлээн авагчдын ойролцоо барилгын ажил, дуу чимээний түвшинг аль болох бага байлгаж, зэрлэг амьтдад учруулах нөлөөллийг нь бууруулна.</li> <li>- Зохистой төлөвлөлт, хэрэгжүүлэлтээр дамжуулан хөрс малтлага болон барилгын бусад үйл ажиллагааны явцад зэрлэг ан амьтдын амьдрах орчинд учруулах хохирлыг аль болох бага байлгахад анхаарах хэрэгтэй. Ажилчид ан хийхийг хатуу хориглож, менежментийн баг хууль, журмын хэрэгжилтийг хангуулах хариуцлага хүлээнэ.</li> <li>- Биологийн олон янз байдлын төлөвлөгөөнд санал болгосон нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх бөгөөд үүнд Угтаалцайдам сум дахь барилгын үйл ажиллагааны хугацааг хязгаарлаж, богино хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд хэрэв барилгын ажил нь улаан буга, цагаан зээрийн нүүдэлд нөлөө үзүүлэхээр байвал нүүдлийн үеэр барилгын ажил явуулахаас зайлсхийх.</li> </ul>	<p>Туслан гүйцэтгэгчид</p>	<p>ТУА/ЗТХЯ</p>	<p>Гэрээ гүйцэтгэгчийн төсөв</p>
---	--	----------------------------	-----------------	--

Газрын бүрэн бүтэн байдал ба газар ашиглалтын хэв маяг	<ul style="list-style-type: none"> <li>- Сонгосон, зориулалтын талбайнуудад малтаж гаргасан материалуудыг овоолох.</li> <li>- Тээврийн хэрэгсэл/барилгын машин механизмыг төслийн гадна талбайд аль болох бага зорчуулах.</li> <li>- Амьтдын одоогийн амьдрах орчинг талбайн зураг төсөлд нэгтгэх.</li> <li>- Амьдрах орчноо алдсан ан амьтдад шинээр амьдрах орчин бий болгож, талбайн экологийн боломж, бололцоог сайжруулах.</li> </ul>	Туслан гүйцэтгэгч	ТУА/ЗТХЯ	Гэрээ гүйцэтгэгчийн төсөв
Барилгын үйл ажиллагаануудын улмаас үүсэх усны бохирдол  Барилгын талбайн бэлтгэл ажлын явцад шатахуун, тос зэрэг аюулт бодисуудыг буруу хадгалж, хэрэглэсний улмаас асгарч, урсаж, гүний усны нөөцийг бохирдуулах магадлалтай.  Барилгын ажлын үеэр болон дараа нь усыг хямгадахгүй хэрэглэснээр усны нөөц шавхагдах магадлалтай.	<ul style="list-style-type: none"> <li>- Барилгын ажлын явцад усыг зохистой хэрэглэж, хэрэглээг хянах.</li> <li>- Барилгын талбайд ус нөөцлөх байгууламж сууринуулах.</li> <li>- Барилгын талбайн хаягдал усны хэмжээг аль болох бага байлгах.</li> <li>- Цемент зуурах, гадаргын урсац, цэвэрлэх бохир ус зэрэг барилгын хаягдал ус голцуу хатсан байдаг.</li> <li>- Тосны агууламжтай хаягдал ус ялгаруулахаас зайлсхийж, талбай дээр машин, механизмыг цэвэрлэхгүй байх. Хэрэв цэвэрлэх шаардлагатай бол хаягдал усыг бөөгнүүлж, тос ялгах сав гарган, тус тусад нь салган авна.</li> <li>- Ус авах хоолой зэрэг дэд гадаргуун хоолойнуудыг зохистой хэмжээнд арчилж, орчин тойрны байгалийн хөрсөнд асгахаас сэргийлэх хэрэгтэй. Хоолойн болзошгүй гэмтлийг хянаж, тогтмол шалгаж, эсвэл өрхийн бохир усны хоолойд хяналтын тоног төхөөрөмж сууринуулах хэрэгтэй.</li> <li>- Бохир ус зайлцуулах цэгүүдийг тогтмол арчилна.</li> <li>- Төслийн хэрэгжилтэд зориулж голоос гүнийн ус гарган авсан тохиолдолд голд усны хаалтыг бодолцож, тоолуур сууринуулна.</li> <li>- Тоолуурыг ус хадгалах сав, гол, ус гадагшуулах хоолойн гарц хэсэгт сууринуулна.</li> <li>- Ус ашиглах зөвшөөрөл болон бохир ус зайлцуулах зөвшөөрөл авч, ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг тухай бүрд нь төлнө.</li> </ul>	Туслан гүйцэтгэгч	ТУА/ЗТХЯ	Гэрээ гүйцэтгэгчийн төсөв

<p>Барилгын байгууллагуудын малтлага, хадгалалт, яндангаас гараж хүлэмжийн хийн ялгарлаас үүдэх агаарын бохирдол</p> <p>Талбайн бэлтгэл ажлын явцад хүнд даацын ачааны машин, генераторууд, ахуйн хогийн цэгүүд/хогийн сав, бохир усны хоолой задарсны улмаас ялгарах CO, SOx, NOx агаарын чанарыг түр хугацаанд дордох боломжтой. Тос, шатахууны бүтээгдэхүүнийг буруу хадгалсны улмаас алдагдсан химийн бодисууд мөн агаарын чанарыг доройтуулна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Малтлага, хадгалалтад зориулж барилгын шинэ талбайн хөрсөнд ус цацаж, тоосыг аль болох бага дэгдээх хэрэгтэй.</li> <li>- Ажилтнуудыг тоосны маск зэрэг хувийн хамгаалах хэрэгсэл, хувцсаар хангах.</li> <li>- Бөөмийн хувьслыг дараахын тулд хөрсийг тогтмол усаар зөөлрүүлэх овоолго.</li> <li>- Шаардлагагүй ялгарлыг аль болох бага байлгахын тулд тоног төхөөрөмж, машин, механизмуудыг арчилж, сайн нөхцөлд байлгах.</li> <li>- Төслийн талбайд шатамхай материалуудыг зөвшөөрөхгүй байх хэрэгтэй.</li> <li>- Төслийн зориулалтын талбайд тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлах</li> <li>- Хаягдлын холбогдох зөвшөөрлүүдийн материалуудыг боловсруулж, хүсэлт гаргах;</li> <li>- Малтлагын талбайн ойр орчимд түр хугацаанд хашаа босгох;</li> <li>- Хүчтэй салхтай өдрүүдэд барилгын ажлыг зогсоох;</li> <li>- Хөрс хадгалах менежментийг бэхжүүлж, хучилтын болон усалгааны төлөвлөгөөнүүд боловсруулах. Талбайнуудыг голоос багадаа 200 м зайд байлгах хэрэгтэй. Хаягдлыг цаг тухай бүрд нь тээвэрлэх хэрэгтэй; Тээврийн улмаас дэгдэх тоос, яндангийн утаанд тааруулж</li> <li>- Тоосжилтыг дараахын тулд тогтмол ус цацах; цэвэршүүлсэн бохир усиг үүнд ашиглах боломжтой</li> <li>- Материал тээвэрлэх явцад хаягдуулахгүй байх үүднээс гадуур нь бүрхэвч ашиглана; хэт ихээр ачихыг зөвшөөрөхгүй; тээврийн чиглэл, хуваарийг сайтар боловсруулж, оршин сууучдын тав тухыг алдагдуулахгүй байх хэрэгтэй.</li> <li>- Хаягдал хөрсийг аль болох дахин ашиглах эсвэл тухай бүрд нь хогийн цэгт хаях. 8. Хаягдал шатаахыг (барилгын материал, хаягдол тос г.м) зөвшөөрөхгүй.</li> <li>- Ачааны хуучин машинууд, генераторууд ашиглахаас зайлсхийх, эсвэл засвар үйлчилгээг байнгын найдвартай хийх. Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн хүлэмжийн хийн ялгарлын хуульд заасан шалгууруудыг мөрдөх.</li> <li>- Төслийн талбайд замын тэмдгүүд байрлуулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аль болох бага байлгаж,</li> </ul>	<p>Туслан гүйцэтгэгч</p>	<p>ТУА/ЗТХЯ</p>	<p>Гэрээ гүйцэтгэгчийн төсөв</p>
---	--	--------------------------	-----------------	----------------------------------

	<ul style="list-style-type: none"> <li>- боломжтой бол тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулж хатуу хучилт ашиглах.</li> <li>- Төслийн талбайн тоосжилтын асуудлыг шийдэхийн тулд усалгааг тогтмол хийж болно.</li> <li>- /800,000 м2*2л усалгаа/. Усалгаанд гүний ус ашиглахаас зайлсхийх.</li> <li>- Төвлөрсөн хогийн цэгийн хаягдлыг барилгын ажлын явцад болон дараа тогтмол устгана. Барилгын хог хаягдлыг төслийн талбайд овоолохоос зайлсхий.</li> <li>- Ахуйн хаягдал, ачааны машины эд анги, хөдөлгүүр зэрэг хог, хаягдлыг ялгаж, зохих хогийн саванд хадгална. Бүх төрлийн хаягдалд дахин боловсруулах бодлогыг боломжтой бол хэрэгжүүлэх хэрэгтэй бөгөөд дахин ашиглах боломжтой усыг хүүчин түүхий эдийн жижиглэн худалдааны цэгүүд болон аж үйлдвэрүүдэд дамжуулна.</li> <li>- Шатахуун, хийг CO2 аль болох бага ялгаруулдаг найдвартай ханган нийлүүлэгчээс авахыг хичээх хэрэгтэй. Агаар бохирдуулагчийн ялгаруулалтыг аль болох бага байлгах үүднээс Евро 5 шатахуун ашиглахыг дэмжиж байгаа.</li> </ul>			
Газар, шорооны ажил, тээвэрлэлт, хаягдал шороог зайлцуулах, ахуйн хатуу хог хаягдаас гарах хатуу хог хаягдлын бохирдол	<ul style="list-style-type: none"> <li>- Хаягдлыг эх үүсвэр дээр нь ялгаж, өөр ангиллуудаар хаяхыг дэмжих.</li> <li>- Их хэмжээний хатуу хог хаягдлыг хаягдал зохицуулдаг тусгай зөвшөөрөлтэй компанийтай гэрээ байгуулж хаях.</li> <li>- Ахуйн хатуу хог хаягдлыг гэрээ гүйцэтгэгчээр устгуулах хүртэл зориулалтын саванд түр хугацаанд хадгалах.</li> <li>- Бетон, асфальт болон бусад агрегат хаягдлуудыг цуглуулж, боломжтой бол дахин ашиглах.</li> <li>- Хатуу хог хаягдлын хэмжээг аль болох бага байлгах үүднээс дахин ашиглах боломжтой бүх материалуудыг дахин ашиглах хэрэгтэй.</li> <li>- Ариун цэврийн зохих байгууламжуудыг ажилчдад хангах. Тухайлбал шавхуургатай зөөврийн жорлонгууд (шингэн хаягдал).</li> <li>- Зөөврийн жорлонгуудын лагийг хог устгалын бүртгэлтэй компаниудаар зохицуулах хэрэгтэй.</li> <li>- Бетон/агрегатуудын бохир усыг тунадасжилтын саванд хаяж, цэвэр усыг нь дахин ашиглана</li> </ul>	Туслан гүйцэтгэгч	ТУА/ЗТХЯ	Гэрээ гүйцэтгэгчийн төсөв

	<ul style="list-style-type: none"> <li>- Цементийн машин, тоног төхөөрөмжийг угаах талбайг голын сав газраас хол тусгайлан гаргах.</li> <li>- Машин, механизмуудыг ажиллуулах явцад тос асгаруулахгүй байхын тулд бүх тээврийн хэрэгслүүдийг тогтсон станцаас шатахуун авахуулах.</li> <li>- Дахин ашиглах боломжгүй хаягдлыг тухай бүрд нь хогийн цэг гүү тээвэрлэх хэрэгтэй. Тээвэрлэх станцуудад хог хаягдал хаяхыг зөвшөөрөхгүй.</li> <li>- Ухсан нүхийг дүүргэхэд хаягдлуудыг аль болох дахин ашиглаж, нэмэлт хог хаягдлыг орон нутгийн захиргааны заасан овоолгод тээвэрлэнэ.</li> <li>- Хог хаягдлыг барилгын талбайн хогийн савнаас цуглувуулж, цэвэрлэж, тээвэрлэх станцуудад цаг тухай бүрд нь хүргэж өгөх хэрэгтэй.</li> <li>- Өрөмдлөг/овоолгын хаягдлыг аль болох дахин ашиглах хэрэгтэй.</li> </ul>			
Дуу чимээ	<ul style="list-style-type: none"> <li>- Барилгын ажилчид болон зочдод хувийн хамгаалалтын хэрэгсэл олгох.</li> <li>- Машин, механизмаас ялгараах дуу чимээний зөвшөөрөгдсөн хязгаарыг баримтлах.</li> <li>- Барилгын үйл ажиллагаа хэт чанга дуу чимээ ялгаруулахаар байвал орон нутгийн суугчдад мэдээлэх.</li> <li>- Материалуудыг ачиж, буулгах үед тээврийн хэрэгслийг унтрааж, шаардлагагүй утас ялгаруулахаас зайлсхийнэ.</li> <li>- Бага дуу чимээ гаргадаг тоног төхөөрөмжийн хэрэглээг нэвтрүүлнэ; хэт чанга дуу чимээтэй тоног төхөөрөмж ашиглахаас зайлсхийх, тэр дундаа шөнийн цагаар;</li> <li>- Барилгын товыг зөв зохистой хуваарилж, дуу чимээний нөлөөг аль болох бага байлгах;</li> </ul>	Туслан гүйцэтгэгч	ТУА/ЗТХЯ	Гэрээ гүйцэтгэгчийн төсөв
Хөрсний элэгдэл, экологийн орчин  Барилгын ажлын явцад хөрсний нягтрал болон малтлага, суваг шуудуу	<p>Газрын экологийн хувьд</p> <ul style="list-style-type: none"> <li>- Талбайд аль болох ургамал сугалахгүй, гэмтээхгүй байх хэрэгтэй.</li> <li>- Барилгын ажлын явцад цэвэрлэсэн ургамлын бүх угуул аймгийг дахин суулгана.</li> <li>- Барилгын ажлын явцад байгалийн ургамлыг цэвэрлэх зөв зохистой төлөвлөгөө гаргах.</li> </ul>	Туслан гүйцэтгэгч	ТУА/ЗТХЯ	Гэрээ гүйцэтгэгчийн төсөв

<p>зэрэг бусад хөрсний ажлууд өнгөн хөрсийг элэгдүүлж, ургамалжилтыг алдагдуулдаг. Химийн бодис, тос, шатахууныг санамсаргүй асгасны улмаас хөрс бохирдож, ургамлын аймгийн амьдрах орчинг устгах магадлалтай. Үүнээс гадна хаягдал материалууд ялгаруулж, лаг хаягдах, алдагдах зэрэг нь өнгөн хөрсийг доройтуулах боломжтой. Тос асгаруулахгүй байх арга хэмжээг гэрээ гүйцэтгэгч авч хэрэгжүүлэхээр байгаа.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Буцааж дүүргэх, тохижилтын үйл ажиллагаанд ухсан материалуудыг дахин ашиглахыг дэмжих.</li> <li>- Бохир ус, борооны ус зайлцуулах зөв зохистой, ажиллагаатай шугамуудыг сууринуулах.</li> <li>- Өнгөн хөрсийг хадгалж, газрын нөхөн сэргээлт, тохижуулалтад ашиглах;</li> <li>- Газар чөлөөлөлтийг аль болох бага байлгаж, өвсөрхөг болон ой модтой газрыг хамгаалах ажлыг дэмжих зорилгоор барилгын талбайг олж авсан эсвэл тусгайлан зориулсан талбайгаар хязгаарлах хэрэгтэй.</li> <li>- Барилгын нэгдсэн кэмпүүд байгуулах хэрэгтэй, эсвэл олон өөр газар кэмп барихаас сэргийлж нутгийн оршин суугчдын сууцыг ашиглана; өөр өөр газруудад хог овоолохоос зайлсхийх.</li> <li>- Ажилчид дунд зэрлэг амьтдыг хамгаалах сэтгэлгээ суулгах ажлыг дэмжиж, ан хийхийг хориглох.</li> <li>- Хөрсний суралыг хянах арга хэмжээнүүдийг хатуу хэрэгжүүлэх.</li> <li>- Тендерийн баримт бичиг, ажлуудын гэрээнд байгаль орчныг хамгаалах шаардлагуудыг тусгах хэрэгтэй.</li> <li>- Барилгын ажил усны системийн хажууд байрласан байвал барилгын нэгж, гэрээ гүйцэтгэгчид, дотоодын мэргэжилтнүүд, туршлагатай загасчдаас техникичдийг бүрдүүлж, загасны чухал аймгийн үйл ажиллагааг хянана. Барилгын талбайд загасны сүрэг ирж явааг тогтоосон бол тэдгээрийг хөнөөхгүйн тулд барилгын ажлыг түр зогсоож, явуулсныхаа дараа үргэлжлүүлнэ. Эдгээр дархан цаазат загаснуудад хохирол учруулсан нь тогтоогдвол загасыг аврах ажиллагааг яарлтай явуулж, орон нутгийн захиргаанд мэдэгдэнэ.</li> <li>- Бүх хаягдлыг цуглуюулж, цэвэршүүлэх/хаях хэрэгтэй. Усны системд санамсаргүй байдааар хаягдал алдагдахыг зөвшөөрөхгүй.</li> <li>- Барилгын бус талбайн гадаргууг доройтуулахаас сэргийлж, авто замыг зөвшөөрөгдсөн зураг төслийн дагуу барьж байгуулна.</li> </ul>			
--	---	--	--	--

	<ul style="list-style-type: none"> <li>- Барилгын ажлын явцад ногоон талбай байгуулахын тулд талбайгаас ухсан үржил шимтэй өнгөн хөрсийг зориулалтын бэлтгэсэн талбайд хадгална.</li> <li>- Төслийн талбайг чийгшүүлж, ургамлын бүрхэвчийг хэвээр нь хадгалахын тулд дуслаар услах системийг тогтооно.</li> <li>- Нэмэлт шороон зам (хатуу хучилтгүй) гаргуулахгүйн тулд төслийн талбайд замын тэмдгүүд байрлуулна. Боломжтой бол тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулсан хатуу хучилттай талбай гаргах. Хөрсөнд шаардлагагүй нягтрал үүсгэхгүйн тулд барилгын нэн чухал талбайнүүдад автомашины хөдөлгөөнийг хязгаарлах. Түр хугацааны замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө боловсруулах.</li> <li>- Барилгын ажлын явцад болон дараа ялгарах хатуу хог хаягдлуудыг/бордоонд ашиглаж болох, болохгүй/цуглуулна.</li> <li>- Техникийн үзлэгүүдийг тогтмол явуулж, тээврийн хэрэгсэл, замын засварыг товлоно. Авто замын зогсоолын аюулгүй орчныг тогтмол хянаж, шатахууны төрлийн бүтээгдэхүүн санамсаргүй газар асгарсан тохиолдолд яаралтай хариу арга хэмжээ авна. Санамсаргүй асгасан үед авах яаралтай арга хэмжээний төлөвлөгөөг талбай дээр бэлэн байлгана.</li> </ul>			
Биет нөөц	<p>Соёлын биет өв олдсон тохиолдолд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Соёлын ямар нэг биет өв олдсон тохиолдолд барилгын үйл ажиллагааг яаралтай зогсоно;</li> <li>- Соёлын биет өвүүдийг устгах, хохирол учруулах, гутаан доромжлох эсвэл нуух нь Монгол Улсын хуулийн зохицуулалтын дагуу хатуу хориотой.</li> <li>- Дотоодын соёлын өвийн товчоонд яаралтай мэдэгдэж, хэлэлцэнэ;</li> <li>- Дотоодын соёлын өвийн товчоо нарийн судалгаа, шинжилгээ хийж, зөвшөөрөл олгосны дараа л барилгын үйл ажиллагааг үргэлжлүүлж болно.</li> </ul>	Туслан гүйцэтгэгч	ТУА/ЗТХЯ	Гэрээ гүйцэтгэгчийн төсөв
Газар ашиглалт, газрын хүртээмжийг хязгаарласны улмаас оршин суугчдын	<p>Оролцогч талуудыг тодорхойлох, хэлэлцүүлэг өрнүүлэх, мэдээлэл хуваалцах, гомдол барагдуулах механизм бий болгох.</p> <p>Зорчих хөдөлгөөн зөвшөөрөгдвэл оролцогч талуудыг тодорхойлж, хэлэлцүүлэг явуулна. Замын холболт хийгдэх хэсгүүд болон</p>	Туслан гүйцэтгэгч	ТУА/ЗТХЯ	Гэрээ гүйцэтгэгчийн төсөв

амьжиргаанд нөлөөлөл	үзүүлэх	<p>материалуудыг татах талбайн ойролцоо бүх оролцогч тал, тэр дундаа жижиг малчин өрхүүдтэй хэлэлцүүлэг өрнүүлнэ.</p> <p>Төслийн талаарх мэдээллийг орон нутгийн суугчдад хамгийн хүртээмжтэй байдлаар түгээж, хариу хүлээн авах хангалттай хугацаа олгоно.</p> <p>Оршин суугчдын амьжиргаанд учрах нөлөөллөөс зайлсхийх боломжгүй үед ЗТХЯ-ны боловсруулсан НШБХ-нд заасны дагуу RAP-уудыг боловсруулж, шаардлагатай нөхөн төлбөрийг олгоно.</p>			
Хөдөлмөрийн мэнд, аюулгүй байдал	эрүүл	<ul style="list-style-type: none"> <li>- Бүх тоног төхөөрөмжийг хэрэглэхийн өмнө аюулгүй байдлыг нь зохих түвшинд хангаж, шалгана.</li> <li>- Ажилчид шаардлагагүй тохиолдолд илүү цагаар ажиллахгүй байхаар ажлын цагийг зохицуулна.</li> <li>- Замын аюулгүй байдлын зохих тэмдгүүдийг стратегийн дагуу барилгын талбайг тойруулж байрлуулна.</li> <li>- Хүний болон замын хөдөлгөөн ихтэй хэсгүүдэд хурд сааруулагч байрлуулах.</li> <li>- Дэд төслийн туслан гүйцэтгэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлүүдийг аль болох бага байлгах үүднээс сайн туршлагуудыг хэрэгжүүлнэ. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал (ХЭМАБ)-ын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд хувийн хамгаалалтын хэрэгсэл ашиглах, ЗГ-ын холбогдох журмын дагуу боловсруулсан яаралтай хариу арга хэмжээний журам, ХДХВ/ДОХ-ын чиг баримжаа, сургалтууд багтана.</li> <li>- Гэрээт гүйцэтгэгчид барилгын ажлын өмнө эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах бөгөөд үүнд КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх, тархалтыг хяналтдаа авах засгийн газрын холбогдох журмууд, зөвлөмж, олон улсын сайн туршлагыг зөвлөмжүүд багтах бөгөөд ирээдүйд шинэчлэгдэх бүрд нь ашиглана. Эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулахдаа орон нутгийн эрүүл мэндийн байцаагч, ажилтнууд болон бусад нийтийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй зөвшилцнө. Төлөвлөгөөнд барилгын талбайн ариутгал/цэвэрлэгээ, талбай дээр халуун шалгах, зайд барих арга хэмжээнүүд, нүүрний маск, гар угаах</li> </ul>	Туслан гүйцэтгэгч	ТУА/ЗТХЯ	Гэрээ гүйцэтгэгчийн төсөөв

	цэгүүд, ариутгагч гэх мэт хувийн хамгаалалтын хэрэгсэл, ажилчин халдварт авсан тохиолдолд хэрэгжүүлэх журам гэх мэт КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх, хяналтад авах арга хэмжээнүүд багтана.			
Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> <li>- Аюулгүйн малгай, чихний бөглөөс гэх мэт шаардлагатай хамгаалалтын хэрэгслүүдийг ажилчдад хангах.</li> <li>- Халдварт өвчний тархалтыг хязгаарлах шаардлагатай сургалтуудыг ажилчдад орох;</li> <li>- Ажилчдад шаардлагатай сургалтууд явуулж, барилгын кэмпийн менежментийг бэхжүүлж, ХДХВ-ээс сэргийлэх;</li> <li>- Барилгын кэмпийн ариун цэврийн менежментийг бэхжүүлж, хогийн савнуудыг зохицуулж, цэвэрлэх ажилчдыг томилох;</li> <li>- Халдвартгүйжүүлэлт, ариутгал, шумуул устгал явуулах гэх мэт.</li> <li>- Эрчим хүчний менежментийг бэхжүүлж, тэгш бус хэрэглээнээс зайлсхийх;</li> <li>- Ариун цэврийн өрөөний менежментийг бэхжүүлж, тогтмол цэвэрлэх, ариутгал хийх;</li> <li>- Туслан гүйцэтгэгчид олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын сайн туршлагаудыг хэрэгжүүлнэ. Оршин суугчидтай холбогдох, барилгын талбайд болон талбайн ойр орчимд мэдээлэл түгээх, аюулгүй байдлыг хангах хашаа, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ (Монгол хэл дээр) байрлуулж, эрсдэлд тодорхойлсны дагуу талбайд хяналтын ажилтнууд байрлуулж (шөнийн харуул үүнд хамаарна), барилгын талбайд зөвшөөрөлгүй хүн оруулахгүй байх.</li> <li>- Ажилчид авахдаа туршлагаас нь хамаарч орон нутгаас иргэдийг ажиллуулах бөгөөд эрүүл мэндийн үзлэгт хамруулж, бэлгийн замын халдварт өвчний боловсрол олгоно. Ажилчдын кэмп байгуулаагүй дотоодын эрчим хүч, усны хангамж, гал тогоо, ариун цэврийн байгууламжтай (багадаа гол, гадаргуун усны урсцаас хол нүхэн жорлонтой байна) түрээсийн байруудтай гэрээ гүйцэтгэгч тал ярилцана.</li> <li>- Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх (БОНМХ-ний Хавсралт 9)</li> </ul>	Туслан гүйцэтгэгч	ТУА/ЗТХЯ	Гэрээ гүйцэтгэгчийн төсөв
Авто замын үйл ажиллагаа, замын хөдөлгөөний менежмент	<p>Замын хөдөлгөөний дуу чимээ</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дуу чимээний бохирдол өндөр бүсүүдэд дуу тусгаарлагч сүүрилуулах;</li> </ul>	Орон нутгийн захиргааны холбогдох байгууллага	ЗТХЯ	Тодорхой болоогүй

	<p>Замын хөдөлгөөний аюулгүй байдал</p> <ul style="list-style-type: none"> <li>- Замын хөдөлгөөнийг жигд байлгахын тулд зохицуулалтыг бэхжүүлэх.</li> <li>- <i>Өвөл, хүнд цаг агаартай үеийн арчилгаа</i> - хэт хүйтэнд тэсэх, хүчтэй салхтай тэмцэх үйл ажиллагаанууд, шаврын нуранга, үер.</li> <li>- <i>Түргэн хариу үзүүлэх</i> - замын нүхийг засварлах, нөхөх, осол гарсан үед цэвэрлэх, замын хөдөлгөөнийг зохицуулах</li> <li>- <i>Тогтмол арчлах</i> - Бага зэргийн эвдрэлийг тогтоох, ус зайлцуулах хоолойг цэвэрлэх, агуулахын менежмент, замын тэмдэг, тэмдэглэгээг засварлах мөчлөгт засвар</li> <li>- Шинэчлэлтийн төлөвлөсөн ажлууд - ус нэвтрэхээс урьдчилан сэргийлэх, бохир ус зайлцуулах хүчин чадлыг сайжруулах, дахин битүүмжлэх, ослын саадыг хадгалах арга хэмжээнүүд.</li> </ul>			
Хог хаягдлын удирдлага	Хогийн цэг тогтоож, ариун цэврийн алба гарган цаг тухай бүрд нь цэвэрлэх.	Орон нутгийн захиргааны холбогдох байгууллага	ЗТХЯ	Тодорхой болоогүй
Биологийн олон янз байдлын менежмент	<ul style="list-style-type: none"> <li>- Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөний нөлөөллийг бууруулах шалгууруудыг сайтар хэрэгжүүлж, хяналт тавих хэрэгтэй.</li> <li>- Инвазив ургамлын аймгийг тогтмол ажиглах/засаж залруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх</li> <li>- Инвазив ургамал ажиглагдсан дариуд шууд цэвэрлэх/авч хаях</li> </ul>	Орон нутгийн захиргааны холбогдох байгууллага	ЗТХЯ	Тодорхой болоогүй
Шуурга, цас	<ul style="list-style-type: none"> <li>- Халтираа, хүйтнээс ажилчдыг хамгаална. Хүнд цаг агаарт барилгын ажлыг түр зогсоно;</li> <li>- Хүчтэй шуурга болон үзэгдэх орчин тааруу манантай үед (&lt;1км) орох, гарах тээврийн хөдөлгөөнийг түр зогсоох журмыг төсөлд тусгах хэрэгтэй;</li> <li>- Их хэмжээний цас орж, мөстсөн үед хоёрдогч аюул үүсэхээс сэргийлж барилгын бүрэн бүтэн байдлыг шалгана.</li> </ul>	Орон нутгийн захиргааны холбогдох байгууллага	ЗТХЯ	Тодорхой болоогүй

Үерийн хяналт	<ul style="list-style-type: none"> <li>- Үерийн улиралд усны биеийн ойролцоо аливаа үйл ажиллагаа явуулхаас зайлсхийх хэрэгтэй. Үерийн даацын нөлөөллийг аль болох бага байлгах зорилгоор барилгын ажил дууссаны дараа түр хаалтуудыг авна;</li> <li>- Үер ирэхээс өмнө бэлтгэлээ хангах: төслийн ачих/буулгах ажлуудыг түр зогсоож, яаралтай хариу арга хэмжээний төлөвлөгөөнүүдийг турших хэрэгтэй;</li> </ul>	Орон захиргааны нутгийн холбогдох байгууллага	ЗТХЯ	Тодорхой болоогүй
Ачих/буулгах	<ul style="list-style-type: none"> <li>- Ачиж, тээвэрлэх машин механизмууд үйл ажиллагааны явцад гэрэл, дуу чимээгээр анхааруулах төхөөрөмжтэй байх хэрэгтэй.</li> <li>- Өндөрлөсөн гадаргууд хамгаалалтын хашлага, аюулгүйн тор байх хэрэгтэй.</li> <li>- Газраас 2 метр өндөрт ажиллаж буй үед аюулгүй бүс, халтирахаас сэргийлсэн гутал хэрэглэх хэрэгтэй.</li> <li>- Том овортой машин, механизм, эсвэл аюултай байрлалд буй үед аюулгүйн төхөөрөмжүүд ашиглах;</li> <li>- Бүх ажилчдыг аюулгүйн хэрэгслээр хангах; Даац хэтрүүлэхийг зөвшөөрөхгүй.</li> </ul>	Орон захиргааны нутгийн холбогдох байгууллага	ЗТХЯ	Тодорхой болоогүй
Зогсоол, хадгалалт	<ul style="list-style-type: none"> <li>- Хүмүүс болон тээврийн хэрэгсэлд зориулсан авто замын хүртээмж харьцангуй сайн зохицуулагдсан, тодорхой заагдсан.</li> <li>- Тээвэр, ачилтын процессын шинж чанарт тулгуурлаж бүтээгдэхүүнүүдийг зохистой зохион байгуулах хэрэгтэй.</li> </ul>	Орон захиргааны нутгийн холбогдох байгууллага	ЗТХЯ	Тодорхой болоогүй

## **6. ДЭД ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТУУД, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА, ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭЛТ**

**Барилга, сүүрилуулалт үе шатны хэрэгжилтийн зохицуулалт:**

1. Төслийн ерөнхий хэрэгжилт, хяналтыг Монгол Улсын Зам тээврийн хөгжлийн яам хариуцна.
2. Салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулж, уялдуулах зорилгоор Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын удирдлага дор Төслийн удирдах хороог (ТУХ) байгуулах бөгөөд ЗТХЯ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Үндэсний хөгжлийн агентлаг (ҮХА), Зам тээврийн хөгжлийн төв, зорилтот аймгуудын захиргаанууд, Сангийн яам (СЯ)-ны төлөөлөгчид үүнд багтана.
3. ЗТХЯ-ны дор ТУА-ыг байгуулна. ТУА-ны удирдлагыг Зам тээврийн хөгжлийн яам томилоно. ТУА нь төслийн өдөр тутмын ерөнхий гүйцэтгэлийг хариуцах бөгөөд үүнд: (i) үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнүүд, төсөв, тогтмол гаргах тайлангуудыг боловсруулах, (ii) худалдан авах ажиллагаа, санхүүгийн удирдлага, байгаль орчин, нийгмийн нэлөөллийн удирдлагыг зохион байгуулах, үүнд гомдол барагдуулах механизм, биологийн олон янз байдлын хээрийн судалгаа, БОЯБМТ багтана, (iii) төслийн хяналт, үнэлгээ (ТХҮ). ТУА-д хүлээгдэж буй төсөлд тусгайлан зориулсан зохицуулагч, мэргэжилтнүүд, зөвлөхүүдийг СЯ-ны зөвлөмжүүдийн дагуу ажиллуулна.<sup>8</sup>
4. Барилгын гэрээ гүйцэтгэгчид барилгын ажлын явцад дэд төсөл тус бүрд нэлөөллийг бууруулах арга хэмжээнүүд, БОНМТ-нүүд болон тэдгээрийн шинэчилсэн хувилбаруудыг хэрэгжүүлэх үүрэгтэй байна. Гүйцэтгэгчид тендерийн саналын баримт бичигтээ байгаль орчны тодорхойлолтуудад хариулахыг шаардана. Гэрээ гүйцэтгэгч бүр Барилгын байгаль орчны менежментийн төлөвлөгөө (ББОМТ) боловсруулах шаардлагатай бөгөөд үүнд БОМТ-ийн заалтуудыг хэрхэн дагаж мөрдөх талаар тусгаж өгч, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал хариуцсан хүн томилох талаар оруулна.
5. Зөвлөхүүд дэд төсөл тус бүрд техникийн туслалцаа үзүүлж, судалгаа, тайлан боловсруулах зэргээр ТУА болон ЗТХЯ-нд туслах үүрэгтэй. Зөвлөхүүд БОН-ийн баримт бичгүүдийн шалгууруудыг цаашдын судалгаанууд, тайлангууд, тендерийн материалуудад нэгтгэнэ.

**Үйл ажиллагааны шатны хэрэгжилтийн зохицуулалт:**

*Үйл ажиллагааны шатны хэрэгжилтийн зохицуулалтыг ЗТХЯ-тай хэлэлцэж, тохиролцон энд бүртгэнэ.*

---

<sup>8</sup> Олон улсын зээлийн төслүүдийн санхүүжилтийн ашиглалт, хэрэгжүүлэлт, хяналт, үнэлгээний журам.

**Чадавхыг бэхжүүлэх сургалт**

Сургалтын сэдэв	Сургалтын зорилго, агуулгын тойм	Хүлээн авагчид/Оролцогчдын дугаар	Давтамж эсвэл зорилтот огноо	Тооцоолсон зардал (Ам.доллар)
Замын хөдөлгөөний түр менежментийн зөвлөмжүүд	Замын хөдөлгөөний түр зохицуулалт, БОН-ийн дүрэм, журмын тойм, шат дараат алхмуудын зөвлөмж.	Орон нутгийн бүх оршин сууучид, түр хугацаанд зам ашиглаж буй хэрэглэгчид, олон нийт	Барилгын ажлын өмнө, дундуур	Барилгын ёртөг/гэрээ гүйцэтгэгчийг оруулах
БОНМТ-ийн танилцуулга	Талбайн мэдээлэл, бохирдлын эрсдэлүүд, хяналт, хөтөлбөрүүдийг багтаасан БОНМТ-ний тойм. Талбайд тусгайлан зориулсан БОНМТ-үүд, барилгын компаниудын ажилчдад зориулсан хэрэгжилтийн сургалтын бэлтгэл ажил.	ТУА-ны бүх инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	Төслийн эхэнд	
БОНМТ-ний дүгнэлт, БОНМТ-ний давтан сургалт	Шинэ өөрчлөлтүүд, БОНМТ-ний шинэчлэлийг багтаасан БОНМТ-ний дүгнэлт.	ТУА-ны бүх инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	Төслийн эхэнд, шинэчлэхэд	
Төслийн удирдлага, хэрэгжилт	Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх. Донор байгууллагуудад зориулсан дэмжлэг үзүүлэх зарчим.	ТУА-ны бүх инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	Төслийн эхэнд	
Тодорхой бохирдлын эрсдэлүүд, хяналтуудын талаарх сургалт				
Сургалтын сэдэв	Сургалтын зорилго, агуулгын тойм	Хүлээн авагчид/Оролцогчдын дугаар	Давтамж эсвэл зорилтот огноо	Тооцоолсон зардал (Ам.доллар)
Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ, Нүүлгэн шилжүүлэлтийн үйл	Нүүлгэн шилжүүлэх журам	ТУА-ны бүх инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	Төсөл хэрэгжилтийн явцад	

ажиллагааны төлөвлөгөө				
Яаралтай хариу арга хэмжээний төлөвлөгөө	Талбайн “болзошгүй ослын хувилбар”-ыг тодорхойлж, болзошгүй гамшигийн нөхцөл байдалд хариу арга хэмжээний үйл ажиллагааг хэрхэн төлөвлөх.	ТУА-ны инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	бүх	Төсөл хэрэгжилтийн явцад
Агаарын чанарыг хянах	Орчны агаарын чанар, ТХАЗ-үүд, тоосонцор, озон задлагч бодисууд (ОЗБ), хүлэмжийн хий	ТУА-ны инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	бүх	Төсөл хэрэгжилтийн явцад
Ус хэмнэх	Усны хяналт, менежмент, боловсруулсан усны дахин ашиглалт, дахин боловсруулалт	ТУА-ны инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	бүх	Төсөл хэрэгжилтийн явцад
Бохир ус, орчны усны чанар	Шингэн хаягдлын чанар, гадаргуун усанд урсгах, ариутгах татуургын системд хаях, цэвэршүүлсэн бохир усыг газар ашиглах, септик системүүд, бохир усны удирдлага	ТУА-ны инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	бүх	Төсөл хэрэгжилтийн явцад
Аюултай материалын менежмент	Аюултай материалуудын ерөнхий менежмент, Аюулын түвшингийн үнэлгээ, менежментийн арга хэмжээ	ТУА-ны инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	бүх	Төсөл хэрэгжилтийн явцад
Галын аюулгүй байдал	Гал, тэсрэлтээс сэргийлэх, хяналтын арга хэмжээнүүд	ТУА-ны инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	бүх	Төсөл хэрэгжилтийн явцад

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, гамшгийн үеийн бэлтгэл ажил, хариу арга хэмжээ, олон нийтийн оролцоог хангах, мэдлэг олгох ажлууд	ТУА-ны инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	бүх	Төсөл хэрэгжилтийн явцад	
Хог хаягдлын менежмент	Хог хаягдлын ерөнхий менежмент, Хог хаягдлын менежментийн төлөвлөлт, Дахин боловсруулах, Дахин ашиглах, Цэвэршүүлэх, хаях, Хаядлыг хадгалах, Тээвэрлэх, Цэвэрлэж хаях, Худалдах, Засгийн газрын хаягдал хариуцсан гэрээ гүйцэтгэгчтэй хамтрах, Эрүүл мэндийн хаягдал	ТУА-ны инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	бүх	Төсөл хэрэгжилтийн явцад	
Уур амьсгалын өөрчлөлт ба дасан зохицох (хөтөлбөрийн хүрээнд шаардлага хангасан төслүүдэд хамаарна)	Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цас орох, үер буух, Монголд зуд тохиох, тэдгээрийн барилгын үеэр болон дараах үйл ажиллагаанд учруулах нөлөө	ТУА-ны инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	бүх	Төсөл хэрэгжилтийн явцад	
Нөлөөллийг бууруулах инженерчлэл, барилгын сайн туршлага	Барилгын дуу чимээний туршлага.	ТУА-ны инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	бүх	Төсөл хэрэгжилтийн явцад	
Хөдөлмөрийн хүрээний менежмент	Хүлээн зөвшөөрөгдөх туршлага, үл нийцэх байдлын шат дараат зөвлөмж	ТУА-ны инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	бүх	Төсөл хэрэгжилтийн явцад	ТУА-ны сургалтын төсөв

Байгаль орчны практикийн журам	Хүлээн зөвшөөрөгдөх туршлага, үл нийцэх байдлын шат дараат зөвлөмж	ТУА-ны инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	бүх Төсөл хэрэгжилтийн явцад	ТУА-ны сургалтын төсөв
Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө	Хүлээн зөвшөөрөгдөх туршлага, үл нийцэх байдлын шат дараат зөвлөмж	ТУА-ны инженерүүд/гэрээ гүйцэтгэгчид	бүх Төсөл хэрэгжилтийн явцад	ТУА-ны сургалтын төсөв

## **7. МЭДЭЭЛЭЛ ИЛ БОЛГОХ, ОЛОН НИЙТТЭЙ ЗӨВЛӨЛДӨХ**

БОНМТ-ийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад талуудын оролцог хангах ажлуудыг хэрэгжүүлнэ. Үүнд оролцогч талуудыг тодорхойлох, шинжлэх, төслийн мэдээлэл болон БОНМТ-ийн төслийг олон нийтэд мэдээлэх, БОНМТ-ийн төсөлд хэлэлцүүлэг явуулах, оролцогч талуудын байр суурь, саналуудыг хэрхэн бодолцож, БОНМТ-д тусгах зэрэг ажлууд багтана.

Угтаалцайдам, Цээл сумуудын иргэдийн төлөөлөгчидтэй урьдчилсан хэлэлцүүлгүүдийг 2021 оны 9-р сарын 9-нд цахимаар хийсэн. Илүү лавшруулсан хэлэлцүүлгийг тесэл эхлэхийн өмнө эрүүл мэнд, аюулгүй байдлын шалгууртай уялдуулан зохион байгуулна.

Хавсралт 1-д цахим уулзалтад оролцсон талуудын бүх асуудал, анхаарах хэрэгтэй зүйл, хүсэлтүүд багтаав.

Мэдээлэл түгээх, олон нийттэй хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг ажлууд БОНМХ, SEP-ийн шалгууруудын дагуу явагдана

## **8. ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ**

Олон нийтээс ирүүлсэн гомдлыг шийдвэрлэх нь Гомдол барагдуулах механизм (ГБМ)-ын гол зорилго. ГБМ-ыг дэд төсөл тус бүрд, холбогдох хуулиуд, Засгийн газрын туршилагын дагуу байгуулна.

ESS10-ийн хүрээнд зээлдэгч тал/ЗТХЯ нь төслийн нөлөөлөлд өртсөн, төслийн БОН-ийн гүйцэтгэлтэй холбоотой талуудын санал, гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэх зорилгоор ГБМ-ыг байгуулж, хэрэгжүүлнэ. ГБМ-д дараах зүйл багтах боломжтой: (а) Хэрэглэгчдийн гомдлоо хүргүүлэх өөр өөр хувилбарууд, үүнд биеэр хүргүүлэх, утас, мессеж, шуудан, имейл, веб хуудсаар өгөх байж болно; (б) гомдлыг бичгээр болон мэдээллийн санд бүртгэх; (с) Олон нийтэд мэдээлэх журам, Хэрэглэгчид гаргасан гомдлоо шийдвэрлүүлэхээр хүлээх хугацааг тогтоох, гомдолд хариу өгөх, шийдвэрлэх; (д) Гомдол барагдуулах явц, удирдах бүтэц, шийдвэр гаргагчдын мэдээллийг ил тод байлгах; (е) Гаргасан гомдлыг шийдвэрлээгүй, хангалтгүй шийдвэрлэсэн тохиолдолд шүүхэд хандах хувилбар. Төслийн гомдол барагдуулсан байдал нь хангалтгүй байгаа үед зуучлах хувилбарыг гомдол гаргагчид санал болгоно. ESS2-ийн шалгуурын дагуу бүх ажилчин, гэрээ гүйцэтгэгчид зориулж ГБМ гаргаж, ажлын байрны асуудлаарх гомдлыг нь хүлээн авдаг байлгана. ГБМ-ын талаар ажилд ороход нь мэдээлж, ГБМ-ын ашиглалтыг өөрийнх нь эсрэг ашиглахаас хамгаалж, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын гарга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.

ТУА нь ГБМ-ын хэрэгжилтийн журмуудыг боловсруулж, олон нийттэй хэлэлцүүлэг хийх үеэр танилцуулж, төслийн туршид Монгол хэл дээр оролцогчдод нээлттэй байлгана. Гомдол гаргасан үед дараах дөрвөн үе шатаар шийдвэрлэнэ. Үүнд:

1-р үе шат: Орон нутгийн шатанд шийдвэрлэх, ГБМ-ыг хүртээмжтэй байлгах: ГБМ-ын систем нь нөлөөлөлд өртсөн хүмүүст (оршин суууч, орон нутгийн бизнесийн байгууллагуудын төлөөллүүд, гэрээ гүйцэтгэгчдийн ажилчид) гомдол гаргах/сэтгэгдэл хүргүүлэх, олон өөр хувилбараас өөрт хамгийн тохирохыг нь сонгох боломж олгоно. Нөлөөлөлд өртсөн хүний гомдлыг санал, гомдлын нэгдсэн системтэй холбогдсон ЗТХЯ-ны нэгдсэн төв веб серверт шүүд бүртгэнэ. Гомдол бүртгэхдээ санал/гомдлын асуудал, нөлөөлөлд өртсөн хүний нэр, холбоо тогтоох мэдээлэл, гомдол гаргасан өдөр гэх мэт мэдээллийг багтаана.

2-р үе шат: ЗТХЯ-ны Гомдлын шалгуур үзүүлэлтийг үнэлэх, шийдвэрлэх явц. Хүлээн авсан гомдлуудыг ТУА эсвэл холбогдох газар/тасаг/нэгжийн зохих мэргэжилтэнд хариуцуулна. Асуудлыг тогтоож, шийдвэрлэхд ТУА алхмууд авах хэрэгтэй. Ингэхдээ гэрээ гүйцэтгэгч талыг залруулах арга хэмжээ авахыг зөвлөх хэрэгтэй болж болно. Гэрээ гүйцэтгэгч тал

гомдолд шийдэл олох ажлыг хэрэгжүүлж, үр дүнг нь ТУА-д танилцуулж, Дб-нд мэдэгдэх хэрэгтэй. Тухайн гомдлын төрөл, нарийн төвөгтэй байдлаас хамаарч ТУА/ЗТХЯ гомдлыг хүлээн авснаас хойш тухайн асуудлыг 1-30 хоногт шийдвэрлэх боломжтой.

3-р үе шат: ТУА-ын удирдах хороогоор гомдлыг шийдвэрлүүлэх. Гомдлын асуудлуудыг ТУА судалж, 3-р үе шат эхэлснээс хойш 10 хоногт олон талт уулзалтууд зохион байгуулж, 10 хоногт шийдлийг хэрэгжүүлнэ.

4-р үе шат: Илүү өндөр эрх мэдэлтэй байгууллагын шийдвэр. Хэрэв гомдлыг шийдвэрлээгүй бол, нөлөөлөлд өртсөн тал шүүхээр дамжуулах хуулийн нөхөн төлбөр нэхэх боломжтой.

#### **Зам, тээврийн хөгжлийн яам**


Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө 13, Засгийн газрын 13-р барилга,  
ЗИП:14251

Утас: 976-(51)263179; Факс: (976-11)-312315; И-мейл: [info@mrtd.gov.mn](mailto:info@mrtd.gov.mn)

Веб хуудас/веб маягт: <https://mrtd.gov.mn/feedback/form>

Фейсбууц хуудас: <https://www.facebook.com/MRTD.GOV.MN>

Твиттер хуудас: <http://twitter.com/MrtdGovMn>



## **9. ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ, БА БАЙГАЛЬ ОРЧНЫ МОНИТОРИНГ**

Дэд төслийг хэрэгжүүлэх агентлаг, хяналтын инженер, хяналтын гаднын ажиглагчдын ТУА-нд тайлагнах үүрэг хариуцлага, шаардлагыг дор багтаав

ТУА-ын аюулгүй байдлын ажилчид (байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүд) энэхүү ТОТ-ний дагуу талуудын оролцоог үргэлжлүүлэн хангах бөгөөд ингэхдээ оролцогч талуудтай байгуулсан харилцаа, оролцоог хангах суваг дээр тулгуурлана. ТУА нь тэр дундаа төслийн оролцогч талуудын байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн санал хүсэлтийг авч, Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөөний нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

Хэлэлцүүлэг, нийтэд мэдээлэх үйл ажиллагаануудыг төслийн хагас жилийн төслийн тайланд тоймлож, Дэлхийн Банканд тайлагнана. Гүйцэтгэлийн хэд хэдэн гол үзүүлэлтүүд (ГГҮ)-ийг ТУА тогтмол хянах бөгөөд дараах параметрүүд үүнд багтана:

- Тайлант хугацаанд (жишээ нь сар, улирал, жил тутамд) зохион байгуулсан зөвшилцөх уулзалтууд болон олон нийтийн бусад хэлэлцүүлэг/форумуудын тоо.
- Олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаануудын давтамж.
- Тайлант хугацаанд (жишээ нь сар, улирал, жил тутамд) олон нийтээс хүлээн авсан гомдлуудын тоо, тэдгээрээс хугацаанд нь шийдвэрлэсэн гомдлуудын тоо.
- Хүлээн авсан гомдлуудын төрөл;
- Үндэсний хэвлэлийн байгууллагуудаар хэвлэж, нийтэлсэн материалуудын тоо.

Барилгын гэрээ гүйцэтгэгчид дэд төсөл тус бүрд нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хариуцна. Гэрээ гүйцэтгэгчид тендерийн саналаар хүргүүлсэн баримт бичгүүддээ байгаль орчны техникийн үзүүлэлтүүдэд хариулахыг шаардана. Гэрээ гүйцэтгэгч тус бүр Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ)-г боловсруулах шаардлагатай бөгөөд байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хариуцсан хүн томилно. Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал хариуцсан ажилтан нь БОНУТ-ын хэрэгжилтийн тайланг ТУА-д хүргүүлж, үнэлгээ гаргуулна. ТУА болон гаднын мэргэшсэн зөвлөхүүд үр дүнгүүдийг нь баримтжуулж, БОН-ийн хяналтын тайланг хагас жилд тутам боловсруулж, Дэлхийн Банканд мэдээлнэ.

Төслийн барилга, үйл ажиллагааны шатуудад байгаль орчны хүчин зүйлсийг нь тогтмол хянах нь суурь нөхцөл байдлын байгаль орчны статусыг үнэлэхэд чухал ач холбогдолтой. Хянасан өгөгдөл нь төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны чанарт гарсан ямар нэг өөрчлөлт, цаашлаад байгаль орчныг хамгаалах зорилгоор нөлөөллийг бууруулах зохих арга хэмжээний үзүүлэлт болох боломжтой. Шаардлагатай тохиолдолд хяналтын төлөвлөгөөг шинэчилнэ.

Хяналтын параметрүүд, ашиглах арга барил, сорил авах байршил, хэмжих давтамж, зөв зохистой арга хэмжээ авах шаардлагатай арга хэмжээний үзүүлэлтийг илрүүлэх хязгаар, босго үзүүлэлтийн тайлбар зэрэг хяналтын дэлгэрэнгүй арга хэмжээнүүдийг багтаасан хяналтын төлөвлөгөө бүхий БОМТ-үүд орсон БОН-ийн баримт бичгүүдийн бүрэн бүтэн байдлыг ЗТХЯ, ТУА хангана. Хяналтын төлөвлөгөө нь нөлөөллийн бүсэд хийгдэх дэд төсөл тус бүрийн нөлөөллийн талбайн байгаль орчинд анхаарна. Барилгын ажил, үйл ажиллагааны шатанд хяналтын ажлуудын хэмжээг дэд төслүүдийн эрсдэлүүд болон нөлөөлөлтэй уялдуулна.

Нөлөөллийг бууруулах ажлуудын хэрэгжилтийг БОМТ-д заасан шалгууруудын хүрээнд үнэлэхийн тулд хяналтын ажлуудад комплайенсийн шалгалт багтана. Агаар, дуу чимээ, гадаргын үсны ерөнхий хяналтыг хийх боломжтой бол хэрэгжүүлнэ.

Түүнчлэн барилгын ажлын явцад тулгарсан арга хэмжээнүүд эсвэл асуудлуудыг хяналтад багтаана; залруулах арга хэмжээ зэрэг төслийн зураг төсөл, БОМТ-д орсон өөрчлөлт; төслийн хуулийн гэрээнүүдийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөж буй эсэх.



**Хүснэгт 12. Байгаль орчны хяналтын төлөвлөгөө**

Сэдэв	Хяналтын үзүүлэлтүүд	Байршил	Давтамж	Хэрэгжүүлэгч	Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд
<b>A. Барилгын өмнөх шат</b>					
Агаарын бохирдол	Тоосонцор	Барилгын талбай	Барилгын ажил эхэлмэгц Гомдол авмагц	Дэд төслийн гэрээ хүлээн	Монгол Улсын агаарын байгаль орчны агаарын чанарын стандартууд (MNS 4585: 2007).  MNS 4585-98 агаарын чанарын үзүүлэлтүүд. Ерөнхий шалгуур  MNS 5885: 2008 агаар бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээ. Техникийн ерөнхий шалгуурууд
Дуу чимээ	Дуу чимээний түвшин	Барилгын талбай	Барилгын ажил эхэлмэгц Гомдол авмагц		MNS 4585: 2017 Монгол Улсын агаарын чанарын стандарт - орчны дуу чимээний зөвшөөрөгдөх хэмжээ.  MNS 5002: 2000 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Дуу чимээний хэм хэмжээ, аюулгүй байдлын ерөнхий шалгуурууд
Хөрсний бохирдол	Хүнд металл	Барилгын талбай	Барилгын ажил эхэлмэгц		MNS 5850:2019 хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодисуудын зөвшөөрөгдөх хэмжээ
<b>B. Барилгын ажлын явцад</b>					
Элэгдэл, эвдрэл	Хөрсний элэгдлийн менежментийн арга хэмжээг биелүүлж байгаа эсэх шалгалт	Барилгын талбай, хаягдал хөрсийг хаях талбайнүүд	Сар тутмын барилгын ажлын явцад; хаягдал хөрсийг бүрэн хаясны дараа	Туслан гүйцэтгэгчийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд	Байгаль орчны MNS 5916: 2008. Хөрсний ажлын үеэр өнгөн хөрсийг хуулах, хадгалах.  Монголын хатуу металлын стандарт (MNS 5850: 2008)
Агаарын бохирдол	Талбайн арчилгааны арга хэмжээг биелүүлж	Барилгын талбай, хаягдал хөрсийг хаях	Сар тутмын барилгын ажлын	Туслан гүйцэтгэгчийн байгаль орчин,	Монгол Улсын агаарын байгаль орчны агаарын чанарын стандартууд (MNS 4585: 2007).

	байгаа эсэх шалгалт	талбайнүүд	явлад; хаягдал хөрсийг бүрэн хаясны дараа	нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд	MNS 4585-98 агаарын чанарын үзүүлэлтүүд. Ерөнхий шалгуур  MNS 5885: 2008 агаар бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээ. Техникийн ерөнхий шалгуурууд
Гадаргүү, гүний ус	Бохир усны нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа эсэхийг нүдээр шалгах	Барилгын талбай	Сар бүр	Туслан гүйцэтгэгчийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд	Монгол Улсын байгаль орчин, усны чанарын стандарт  (MNS 4585: 2007).  Монгол Улсын үнданы усны чанарын стандарт  (MNS 0900: 2005).  Монгол Улсын бохир усны чанарын стандарт (MNS 4943: 2011).
Хатуу хог хаягдал	Ахуйн болон барилгын хог хаягдлыг цуглуулж, хаяж байгааг эсэхийг шалгах	Хог хаягдал цуглуулах, хаях талбайнүүд	Сар тутамд	Туслан гүйцэтгэгчийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд	
Аюултай, бохирдуулагч материалууд	Аюултай материалуудыг зохицуулж, дахин боловсруулж байгаа эсэхийг шалгах	Түлш, тос, химийн болон бусад аюултай материалуудыг хадгалах байгууламж. Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зөвшарлах талбайнүүд.	Сар тутамд	Туслан гүйцэтгэгчийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд	Монгол Улсын аюултай хог хаягдлын ангиллын тухай Ерөнхий сайд болон Байгаль орчны сайдын 2015 оны 6-р сарын 29-ний 263 дугаар хамтарсан тогтоол
Нийгэм, эдийн засгийн нөлөөлөл	Барилгын талбайн байдал, аюулгүй нийтийн байдал, ГБМ-ын	Эмзэг хүлээн авагчдын ойролцоо ажлын талбайнүүд	Сар тутамд	Туслан гүйцэтгэгчийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд	

	хэрэгжүүлэлт, олон нийт, ажилчдын осол, олон нийтийн гомдол г.м-ыг нүдээр шалгах.				
	Ойрхон зөрсөн, хугацаа алдаагүй, алдсан, хүний амь үрэгдсэн бүх ослыг бүртгэлжүүлж, олос гаргахгүй байх стандарттай харьцуулж, тайлагнах	Нарны цахилгаан станц	Сар тутамд	Туслан гүйцэтгэгчийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд	
	Ажилчид хувийн хамгаалалтын хэрэгсэл ашиглаж байгаа эсэхийг нь шалгах	Барилгын бүх талбайнүүд	Сар тутамд	Туслан гүйцэтгэгчийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд	
	КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, хяналт, тайланг хэрэгжүүлэх	Барилгын бүх талбайнүүд	Сар тутамд	Туслан гүйцэтгэгчийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд	БОНМХ, дэд БОМТ  Үндэсний ХАБЭМ-ийн журам, стандартууд  Улсын болон аймгийн тусгай хороонуудын КОВИД-19 цар тахалтай холбоотой гаргасан шийдвэрүүд, журмууд, зохицуулалтуудтай холбоотой асуудлууд

## **1. ХАВСРАЛТ 1 ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛҮҮД**

Угтаалцайдам, Цээл сумуудын иргэдийн төлөөлөгчид 2021 оны 9-р сарын 9-нд олон нийтийн цахим хэлэлцүүлгүүдэд оролцсон. Лавшуулсан хэлэлцүүлгийг төсөл эхлэхээс өмнө эрүүл мэнд, аюулгүй байдлын арга хэмжээнүүдтэй холбоотойгоор зохион байгуулна.

### **Цээл сумын хэлэлцүүлэг**

Хэлэлцүүлгийг цахимаар зохион байгуулсан. Оролцогчид сумын захиргааны хурлын өрөөнд цугласан. Нэгдүгээрт, хүлээгдэж буй төсөл болон хэлэлцүүлгийн зорилтыг байгаль хамгаалах мэргэжилтнүүд болон техникийн ажилтан танилцуулав.

Хэлэлцүүлгийн үеэр хөндсөн гол зүйлсийг доор жагсаав.

1. Урт хугацааны туршид авто зам хөгжүүлэх, санхүүжүүлэх хүсэлтийг сумын захиргаа Монгол Улсын Засгийн газарт хүргүүлж, 2018 онд нарийвчилсан зураг төсөл болон холбогдох судалгаануудыг гүйцэтгэсэн. Сумын захиргаа, иргэдийн төлөөлөгчдийн бүлгүүд нарийвчилсан зураг төслийн талаар мэдэж байсан ч нарийн зүйлсийг нь мэдээгүй байсан.
2. Одоогийн зураг төслөөр хөдөө аж ахуйн хоёр талбайг нүүлгэн шилжүүлэх шаардлагатай болно.
3. “Аадгайн Даваа” нь эгц налуу тул өвлийн улиралд хур тунадас ихтэй үед аюултай.
4. Сайжруулсан шороон замыг 1978 онд тавьсан. Замын гол хэрэглээ нь хөдөө аж ахуйн компаниуд, орон нутгийн суугчдын логистикийн холбоог дэмжих. Гэхдээ Орхон-Түүл сүмтай холбогдох нэмэлт чиглэл барьж, умард бүсийн аймгуудаас Улаанбаатар хүрэх замыг 250 км-ээр багасгах нь нэн чухал. Иймд Цээл сумыг хөгжүүлэх нь стратегийн ач холбогдолтой.
5. Борооны улирал бурд ширүүн бороо орж, үер буусны улмаас одоогийн шороон зам хүнд нөхцөлд байгаа.
6. Тухайн авто замыг хөгжүүлэхийг сумын дийлэнх оршин суугчид дэмжиж байгаа.
7. Тааруу нөхцөлд буй шороон замын улмаас хэд хэдэн чиглэлд зам гарч, хөрсийг доройтуулж, малчин өрхүүдийн бэлчээрийн талбайг бууруулсан.
8. Хуурай газар, хүнд машин, механизм, тээврийн ачааны машины хөдөлгөөний улмаас ихээхэн тоос босож, үзэгдэх орчин хязгаарлагдаж, хөдөө аж ахуйн зэргэлдээх талбай тоосонд дарагддаг.
9. Эрэг болон сөрөг нөлөөллүүд ажиглагдсан. Аюулгүй байдал хангагдаагүй, тааруу нөхцөлд буй замын улмаас тээврийн хэрэгсэл доголдох нь буурч, замын ойролцоо аж ахуйн нэгжүүдэд нийгэм, эдийн засгийн үр өгөөж бий болох эрэг үр нөлөөтэй. Сөрөг нөлөөллүүд нь замын хөдөлгөөний ачаалал нэмэгдэж, малын бэлчээртэй мөргөлдөх зэрэг малчин өрхүүдэд асуудал үүсгэхээр байгаа. Барилгын ажлын явцад ажилчдын кэмпт хяналт тавьж, нутгийн оршин суугчдад төвөг үдахгүйгээр зөв зохистой зохицуулах хэрэгтэй.
10. Элсэн Цагаан чиглэлийг тур хугацаанд ашиглах боломжтой.
11. Замын ойролцоо зуны “зуслан” байхгүй, ойролцоогоор зургаан “өвөлжөө” байгаа, нэг бригад, хөдөө аж ахуйн гурван талбайг хувийн хэвшлийн компаниуд эзэмшдэг.
12. Замын зураг төслийн шатанд авто замыг сумын зүүн хэсэгт, төвөөр шууд дайруулалгүй барихыг бид хүссэн.
13. “Аадгайн Даваа овоо” нь 1976 онд баригдсан тул авто замыг “Аадгайн Даваа овоо”-ыг буулгалгүйгээр барихыг нутгийн оршин суугчид хүссэн.

14. Цээл сумд 490 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байдаг. Замд голцуу хүнд даацын машин, механизм явж өнгөрдөг.
15. Цээл сум нь нийт 2900 хүн амтай ч хавар, намрын улиралд хүн амын тоо нь 8000 хүрдэг. Цээл сум нь хамгийн олон буюу 210 хадлангийн талбайтай бөгөөд нийт 12,000 га газрыг хамардаг. 36,000 га талбайг 150 иргэн, 85 аж ахуйн нэгж хөдөө аж ахуйн зорилгоор эзэмшдэг. Цээл сум нь Монгол Улсын жилийн хадлангийн үйлдвэрлэлийн талыг нь дангаараа хангадаг.
16. 76 км урт шороон замыг суудлын машин 3-4 цаг, том оврын машин 6-7 цаг түүлдаг.
17. Дундаж хурд 20-30 км/цаг
18. Дарханы замын бүтээн байгуулалтад сүүлийн 2-3 жилд Сэлэнгэ, Эрдэнэт, Хөтөл сумаас Дархан хүрэхээр дайран өнгөрч буй тээврийн хэрэгслийн тоо эрс нэмэгдсэн.

#### **Угтаалцайдам сумын хэлэлцүүлэг**

Хэлэлцүүлгийг цахимаар зохион байгуулсан. Оролцогчид сумын захиргааны хурлын өрөөнд цугласан. Нэгдүгээрт, хүлээгдэж буй төсөл болон хэлэлцүүлгийн зорилтыг байгаль хамгаалах мэргэжилтнүүд болон техникийн ажилтан танилцуулав.

Хэлэлцүүлгийн үеэр хөндсөн гол зүйлсийг доор жагсаав.

1. 45 км урт шороон замаар хатуу хучилттай замд холбогдоно. Шороон замыг суудлын машин 90 орчим минут, том оврын машин багадаа 2 цаг түүлдаг.
2. Нарийвчилсан зураг төсөл боловсруулж байгааг сумын удирдлага мэдэж байсан ч нарийн мэдээллүүд байгаагүй.
3. Замын хөдөлгөөний ачаалал улирлаас хамаараад өөр байдаг бөгөөд хавар, намрын улиралд нэмэгддэг.
4. Нийт талбай нь ойролцоогоор 20 км үргэлжилдэг бөгөөд ургамлын аймаг, олон талт байдал цөөрсний улмаас хөрс доройтох, цөлжилт явагдаж байгаа.
5. Ойролцоогоор 200 орчим улаан буга (*Cervus Elaphus Linnaeus*) нүүдэллэж, Угтаалцайдам сум болон Төв аймгийн бусад хэдэн sumaар дайрч өнгөрдөг. Иймд амьтдын нүүдлийг дэмжих замын уулзвар хийх нь тоо толгойг нь нэмэгдүүлэхэд тус болно.
6. Монголын цагаан зээр *Procapra gutturosa* өвлийн улиралд нүүдэллэж, тус бус нутгаар дайрч өнгөрдөг бөгөөд хаврын улиралд буцдаг.
7. Замаас 20 км орчим зайд орших голын сав газарт хөрсний элэгдэл явагдсан.
8. Бус нутагт бэлчээрийн талбай хязгаарлагдмал тул малчдын бэлчээрийг хөнгөлөх зорилгоор хадлан хураасны дараа хөдөө аж ахуйн хашаануудыг буулгана.
9. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаануудын улмаас хаврын улиралд хүчтэй салхитай өдрүүдэд тоос болдог.
10. Замын хажуугаар гурван нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагатай болохоор байгаа. Одоо байгаа зам нь сумын төвөөр шууд дайрч өнгөрдөг. Иймд аюулгүй байдлыг хангах үүднээс замыг сумын төвөөр дайруулахгүй байхыг илүүд үзэж байгаа.:
11. Замын дагуу хэд хэдэн малчин өрхийн “өвөлжөө” байгаа бөгөөд мал амьтад замаар аюулгүй дайрч өнгөрөх шаардлагатай.
12. Археологийн талбайнүүд голцуу “Талын уул” орчимд, замаас хол байрласан. Бүсэд өөр мэдрэг талбайнүүд байхгүй.
13. Замын бүтээн байгуулалтад зориулж нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагагүй гэж бид үзэж байгаа.
14. Нийгмийн цөөнх буюу 200 орчим хүн амтай, 40 орчим Казах үндэстэн өрхүүд 1970 оноос хойш багуудын нэгэнд нь суурьшиж байгаа. Авто зам тэдний “өвөлжөө”, “хаваржаа”-аар дайрч өнгөрнө.

15. Зорчигчид, Дарханы замын бүтээн байгуулалтад оролцож буй логистикийн ачааны тээврийн машинууд голцуу Эрдэнэт, Булган, Сэлэнгэ аймгаас дамжин өнгөрдөг.
16. Түр оршин суугчдын тоо хавар, намрын саруудад 200-300 орчмоор нэмэгддэг.
17. Замын тааруу нөхцөл байдал, бид ихээхэн боломжко алддаг. Тэр дундаа малын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжууд. Нийслэлийн агаарын бохирдол, замын хөдөлгөөний асуудал нэмэгдсээр байгаатай холбогдуулан олон хүн Угтаалцайдам сумд оршин суух сонирхолтой болоод байгаа.
18. Хүнд даацын машин, механизмууд сумыг ойр ойрхон дайрч өнгөрдөг. Иймд зураг төслийн шатанд хүчин чадлыг нь бодолцох нь чухал. Угтаалцайдамын хөрс элэгдэх магадлалтай болоод байгаа.

**2. ХАВСРАЛТ 2 “MCPC<sub>GR</sub> ХХК”-ИЙН БОЛОВСРУУЛСАН НАРИЙВЧИЛСАН  
ЗУРАГ ТӨСЛИЙН ТАЙЛАНГИЙН НҮҮР ХУУДАС**



“ЭМ СИ ПИ СИ ЖИ АР”ХХК

ШИФР : 03/18

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ, ЦЭЭЛ, ЗААМАР СУМЫН ТӨВИЙН  
122.399 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН  
НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

**ТАЙЛБАР БИЧИГ**



ЗАХИРАЛ

ЖБАТСАЙХАН

ИНЖЕНЕР

ДЧИНТУШИГ

УЛААНБААТАР 2018

### **3. ХАВСРАЛТ З НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСЛИЙН МАРШРУТЫН КООРДИНАТ**



ESMP Appendix  
Detailed design coorc